

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-23

1.Инновацийн тухай хуулийн биелэлтийн үр дагаварт хийсэн үнэлгээний
тайланг хэлэлцэх 3-23

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны
04 дүгээр сарын 15-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 17 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Номин;
Эмнэлгийн чөлөөтэй: Э.Батшугар;
Тасалсан: Ч.Анар.

**Нэг.Инновацын тухай хуулийн биелэлтийн үр дагаварт хийсэн
үнэлгээний тайланг хэлэлцэх**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал Д.Бумдарь, мөн хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын газрын дарга Б.Бат-Өлзий, мөн яамны Хууль, эрх зүй, виртуал бүсийн үйл ажиллагааны хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Ч.Болор-Эрдэнэ, Салбарын эрх зүйн орчны шинэчлэл, хуулийн хэлтсийн шинжээч Б.Солонго, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, мөн яамны Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга Б.Урьболд, “Дөлгөөнцагаан интернэйшнл” ХХК-ийн судлаач Б.Жавхлан, Монгол Улсын Их Сургуулийн доктор Ч.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, мөн албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Р.Дэлгэрмаа нар байлцав.

Инновацын тухай хуулийн биелэлтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал Д.Бумдарь, “Дөлгөөнцагаан интернэйшнл” ХХК-ийн судлаач Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын газрын дарга Б.Бат-Өлзий нар тус тус танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, А.Ганбаатар, С.Цэнгүүн, Д.Рэгдэл, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын газрын дарга Б.Бат-Өлзий, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, “Дөлгөөнцагаан интернэйшнл” ХХК-ийн судлаач Б.Жавхлан, Монгол Улсын Их Сургуулийн доктор Ч.Ганзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын Д.Рэгдэл, Ж.Золжаргал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Инновацын тухай хуулийн биелэлтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг хэлэлцэв.

Уг асуудлыг 15 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 20 минут үргэлжилж, 11 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
14 цаг 17 минут.*

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Золжаргал: Эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Инновац, цахим бодлогын байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааныг эхэлье. Байнгын хорооны ирцийг танилцуулъя. Анар гишүүн чөлөөтэй, Батшугар гишүүн өвчтэй, Ганбаатар гишүүн ирсэн байна, Золжаргал ирсэн байна, Мөнхсайхан сайд ирсэн байна, Пунсалмаа гишүүн ирсэн байна, Ундрам гишүүн ирсэн байна, Цэнгүүн гишүүн ирсэн байна. Ингээд ирц 54,5 хувьтай байгаа учраас Байнгын хорооны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Галбадрах гишүүн, Галбадрах гишүүн сайн байна уу та, Галбадрах гишүүн ирсэн байна. Ирц 63,6 хувь. Хуралдаан эхэлье.

Хэлэлцэх асуудал нэг хэлэлцэх асуудал санал болгож байгаа. Инновацын тухай хуулийн биелэлтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан хэлэлцэх ийм асуудал байна. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн алга байна. Санал байхгүй тул хэлэлцэх асуудалдаа оръё. Ажлын хэсэг маань орж ирж байна. Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаврыг баталсан. Тус цаглаварт Байнгын хороогоор Инновацын тухай хуулийн биелэлтийн үр дагаварт хийсэн үнэлгээг хаврын чуулганы хугацаанд хэлэлцэхээр тусгасан байгаа. Үүний дагуу Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд захиалга өгөөд, Инновацын тухай хуулийн хэрэгжилт дээр хэрэгжсэн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилтийн үр дагаврын тайланг бүгдээрээ сонсьё.

Инновац технологи, түрүүчийн Байнгын хорооны хурлаар бид Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг сонссон. Тэгээд ерөнхийдөө инновац, технологийг дэмжих тухай ийм хэрэгждэггүй хуулиуд хэд хэдэн хуулиуд бид баталчхаад, эх үүсвэр байдаггүй, нөгөө заалтууд нь олигтой хэрэгжиж өгдөггүй ийм байгаа. 2012 онд Инновацын тухай хууль батлагдсанаас хойш 13 дахь жилдээ явж байгаа боловч ийм үнэлгээ хийгдээгүй байна. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар 5 жил тутамд үнэлгээ хийгдэж байх ёстой. Тэгээд энэ хууль батлагдсанаас хойш хангалттай их хэмжээний хугацаа өнгөрчихсөн байна. Тэгэхээр үнэлгээгээ хийгээд, дүгнэлтээ гаргаад Инновацын тухай хууль, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Шинжлэх ухаан технологийн хууль гээд эдгээр хуулиудыг хэрэгжүүлэх, шаардлагатай нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хийх ийм хэрэгцээ шаардлага гарах байх гэж үзэж байгаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Хаанаас эхэлж байна гэнэ вэ? Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал Бумдарь ирсэн байна, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Онолт, Цахим

хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Салбарын эрх зүйн орчны шинэчлэл, хуулийн хэлтсийн шинжээч Солонго, Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Болор-Эрдэнэ, Мэдээллийн технологийн үндэсний паркийн Хууль, эрх зүй, виртуал бүсийн үйл ажиллагааны хэлтсийн дарга Лхагвасүрэн ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамнаас Шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Баттогтох, Технологи инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга Урьболд ирсэн, ТББ-ын төлөөлөл болоод Дөлгөөнцагаан интернэйшнл компанийн судлаач Жавхлан, МУИС-ийн доктор Ганзориг доктор хүрэлцэн иржээ. Хурлыг, тайланг Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнгийн захирал Бумдарь танилцуулна. Бумдарь захирлыг тайлангаа танилцуулахыг урьж байна. Юу гэнэ ээ? 3 дугаар микрофон нээж өгнө үү. 2 нээчихлээ 2 дээр.

Д.Бумдарь: Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүддээ энэ өдрийн мэндийг мэдье. Миний бие Парламент судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал Бумдарь байна. Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламент судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс Инновацын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Монгол Улсын ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан аргачлалын дагуу үнэлгээ хийлгэх ажлыг хөндлөнгийн байгууллагаар 2024 оны 12 дугаар сард хийж гүйцэтгүүлсэн. Тус ажлын хүрээнд Инновацын тухай хууль, инновацыг дэмжих чиглэлээр гарсан Улсын Их Хурлын тогтоол, холбогдох ЗГ-ын гишүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөө зэргийг үнэлсэн болно. Улмаар Япон, БНХАУ, ОХУ, АНУ-ын инновацыг дэмжихтэй холбоотой хуулийн шинэлэг зохицуулалтыг судалсан байгаа. Монгол Улсын Их Хурлаас 2012 онд баталсан Инновацын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг захиалгаар хийж гүйцэтгэсэн манай судлаач Жавхлан танилцуулна. Баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. 4 номерын микрофон нээж өгнө үү, 4 дүгээр микрофон нээж өгье.

Б.Жавхлан: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Миний бие судлаач Жавхлан. Энэхүү хэрэгжилтийн үр дагаврын судалгааг багаар хийж гүйцэтгээд өнөөдөр та бүхэнд танилцуулах болно. Гүйлгэчих үү? Presentation-ий дараа. Судалгааг мэдээж Монгол Улсын ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасан үндсэн аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн. Тухайн аргачлалд дурдсаны дагуу үндсэн үе шатуудын дагуу хийж гүйцэтгэсэн байгаа. Төлөвлөх үе шат, төлөвлөх үе шат дотроо үнэлгээ хийх шалтгаанаа тодорхойлоод, үнэлэгдэх хэсгийг тогтоогоод, шалгуур үзүүлэлттэй бол харьцуулах хэлбэрийг тогтоосон байгаа. Тэгээд энэ үндсэн дээрээ хэрэгжүүлэх болон үнэлэх үе шатыг тодорхойлоод, тодорхой судалгааг хийж гүйцэтгэсэн байгаа.

Монгол Улсын Их Хурлын 2000, 1998 оны 55 дугаар тогтоолоор анх Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого анх бол 92 оноос хойш бол батлагдсан. Энэхүү бодлогод өөрөө анхны инновацын тухай ойлголтууд тусгагдсан гэж судалгааны багийн зүгээс харсан. Үүний дараа болохоор гол 2020 он хүртэл баримталж явсан баримт бичиг буюу Монгол Улсын ЗГ-ын 2007 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын шинжлэх ухаан технологийг 2007 оноос 2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө гэж батлагдсан. Тус мастер төлөвлөгөөний хүрээнд болохоороо Инновацын тогтолцоог бүрдүүлэх дэд хөтөлбөр гээд тодорхой хөтөлбөрүүдийг батлаад явж байсан. Тухайн хөтөлбөр нь болохоор эхний хөтөлбөр

нь Монгол Улсад үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх 2008-аас 2015 оны хөтөлбөр гээд ер нь хөтөлбөрүүд батлагдаад явж байсан. Мөн Монгол Улсын Их Хурлын 2008 оны 10, 12 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод инновацын хөгжлийн талаар ойлголтууд тусгагдаад, энэ хүрээндээ Инновацын тухай хууль 2012 онд ингээд батлагдаж байсан байгаад байгаа юм. Саяын бодлого, бодлогын баримт бичгүүдийн хүрээнд, хөтөлбөрүүдийн хүрээнд Инновацын тухай хууль тухайн үедээ ЗГ боловсруулагдаад ингээд батлагдаж байсан.

Инновацын тухай хууль 2012 онд батлагдсан буюу өнөөдрөөс хойш 13 жилийн хугацаанд нийтдээ 11 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон байгаа. Гэхдээ энэ дээр агуулгын чанартай нэмэлт, өөрчлөлт нэг л удаа орсон буюу үлдсэн 10 нэмэлт, өөрчлөлт нь болохоор Зөрчлийн тухай хуультай холбоотой эсвэл Төрийн албаны нууцын тухай хууль, Тусгай сангийн хууль, төрийн захиргааны төв байгууллагын нэршил өөрчлөгдөх гэх мэт хэлбэрийн төдий үг, өгүүлбэр өөрчлөгдөх өөрчлөлтүүд орсон байгаа. Нэг 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр ямар зарчмын шинжтэй өөрчлөлт орж ирсэн бэ гэхлээр гарааны компани болон инновацын дэд бүтэцтэй холбоотой өөрчлөлтүүд орж ирсэн гэж харж байгаа. Тэгээд 2012 оноос хойш өнөөдрийг хүртэл бид нарын олж тогтоосноор хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ яг нээлттэй байдлаар хийгдээгүй. Яамд болон холбогдох агентлагууд маань өөрсдөө дор бүрдээ хийж байсан байх. Гэхдээ яг нээлттэй байдлаар хийгдсэн тийм судалгаа нийтлэгдээгүй байна лээ.

Та бүхэн маань мэдэж байгаа байх. Тэгээд яг инновацын энэ асуудал ярихаар яг энэ тоо баримт л яг хамгийн чухал тоо баримт байгаад байдаг. Яагаад энэ тоо баримт ингээд слайд дээр гарч ирж байна вэ гэхлээр өмнөх Байнгын хорооны хурлууд дээр ч гэсэн хэлэлцэгдэж байсан асуудал байна лээ. Яагаад энэ тоо баримт ингээд байн, байн гарч ирээд байна гэхлээр Монгол Улсын ЗГ 2017 оны 295 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах 2017-гоос 2025 оны бодлогод юу гэж заасан байдаг вэ гэхлээр дотоодын нийт бүтээгдэхүүний шинжлэх ухааны салбарын төсвийн эзлэх хувийг 2016 оноос 2020 онд 2 хувь, 2021-ээс 25 онд 2,5 хувьд хүргэнэ гэсэн хөтөлбөр батлаад, хэрэгжүүлээд явсан. Тухайн хөтөлбөр нь нийтдээ 4 жил хэрэгжсэн. 4 жил хэрэгжээд 2021 оны 10 сард батлагдчихсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн удирдлагын тухай хуультай холбогдуулаад тухайн бодлого хөтөлбөр нь хүчингүй болж байсан байгаа.

Тэгэхдээ хүчингүй болсон ч гэсэн нээлттэй байдлаар тухайн хөтөлбөрт хэрэгжилтийн, тухайн хөтөлбөрийг үнэлсэн үнэлгээ нээлттэй байхгүй байгаад байгаа юм. Холбогдох тухайн үед инновац инновацын асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт, соёлын яамнаас хариуцаж ажиллаж байсан. Тухайн үеийн мэдээллүүдээс харахад яг үнэлгээ бол энэ хэрэгжилтийн үнэлгээ хийгдээгүй. Яагаад гэхээр тухайн үедээ ингээд хүчингүй болоод дуусчихсан учраас. Хөтөлбөрийн нэр нь төрөөс шинжлэх, Монгол Улсын ЗГ-ын 2017 оны 295 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах 2017-гоос 2025 оны бодлого гэдэг нэртэй хөтөлбөр байгаа. Энэ нь болохоороо 2021 оны 4 жил хэрэгжээд, 2021 оны 10 сард Хөгжлийн бодлого, төлөвлөлт, удирдлагын тухай хуулиар ер нь ЗГ-тай холбоотой бүх дунд хугацааны хөтөлбөр юмнууд бол бүгд хүчингүй болсон байгаад байгаа. Тэгээд хүчингүй болсноосоо хойш ер нь тэрийг яах вэ дүгнэлт хэсэг дээр нь, гэхдээ одоо ярихад хүчингүй болсноосоо хойш дунд хугацааны инновацтай холбоотой инновацын өндөр хөгжил, өндөр технологи, инновацтай холбоотой, үндэсний инновац хөгжүүлэхтэй холбоотой дунд хугацааны бодлого хөтөлбөр батлагдаагүй байна гэж харж байгаа юм.

Мэдээж саяын 2021 оны 10 сарын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн удирдлагын тухай хууль гарахаас өмнө бол мэдээж тодорхой хөтөлбөрүүд явж байсан. Минийх бол өмнө нь сая хэлсэнчлэн, дараачийнх нь болохоор ямар хөтөлбөр байдаг вэ гэхлээр Монгол улсын ЗГ-ын 2020 оны 1 дүгээр сарын 29-ний 33 дугаар тогтоолоор баталсан Үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх 2020-оос 2024 оны хөтөлбөр мөн баталж байсан. Гэтэл тэр хөтөлбөр нь мөн 21 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуультай холбогдуулаад хүчингүй болж байсан байгаад байгаа. Тэгээд энэ хөтөлбөрүүдтэй холбоотой тухайн үеийн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2019 оны А155 дугаар тушаалаар Төрөөс инновацын талаар баримтлах бодлого гээд 1 дүгээр үе шат буюу 2019-өөс 21 оны үе шатыг батлаад хэрэгжүүлж байсан. Мөн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А190 дүгээр тушаалаар Монгол Улсын ЗГ-ын үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх 2020-оос 24 оны хөтөлбөр, 24 онд хөтөлбөр хэрэгжүүлэх хөтөлбөрийг нарийвчилсан төлөвлөгөө гэж батлаад ажиллаж байсан. Гэвч энэ хөтөлбөрүүд нь яг үндсэн хөтөлбөр нь өөрөө хүчингүй болчихсон учраас тэгээд хэрэгжилт, үр дагавар нь хангалттай үнэлэгдээгүй байгаад байгаа юм.

Тэгээд эндээс хийж байгаа үндсэн дүгнэлт нь юу вэ гэхлээр 2021 оны Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль батлагдсанаас хойш инновац, цахим бодлого болон өндөр технологийн энэ асуудалтай холбоотой дунд хугацааны болон богино хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөнүүд огт байхгүй байна, өнөөдрийн байдлаар хэрэгжихгүй байна, батлагдаж хэрэгжээгүй байна гэж тийм дүгнэлтэд хүрч байгаа юм.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт. Яагаад улсын төсвийн хөрөнгө оруулалт ярьж байгаа вэ гэхлээр Инновацын тухай хууль ер нь аливаа хууль бол 2 зүйлээс хэрэгжих, үгүй нь шалтгаалж байгаа. Нэгд мэдээж санхүү төсөв, мөн 2-т болохоор хэрэгжүүлэх байгууллага. Энэ 2 зүйлээс тухайн хууль хэрэгжилт нь хамаардаг гэж ойлгож байгаа. Тэгэхлээр мэдээж санхүү мөнгөний асуудлыг нь бид тодорхой хэмжээнд харсан. Улсын төсөв яагаад оруулж ирсэн бэ гэхлээр юуны тухай хууль дээрээ Инновацын тухай хууль дээрээ өөрөө санхүүжилт нь юу юунаас бүрдэх вэ гэхлээр түүн дээр хамгийн эхэнд улсын төсөв гэж байж байгаа, улсын төсвийн хөрөнгө оруулалт гээд. Тэгвэл улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нь ингээд Инновацын тухай хууль батлагдсанаас хойш ингээд хараад үзвэл яаж байна гэхлээр Монгол Улсын 2023-аас 17, 2013-аас 17 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт өндөр технологи, үндэсний инновацын чиглэлд хөрөнгө оруулалтын төсөл тусгагдаагүй байна гэж байгаа юм.

Тэгвэл 2000, Монгол Улсын 2018-аас 21 оны Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсанаар Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох тухайн үеийн БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нийтдээ 13 хөтөлбөр бол тусгагдсан байгаа юм хөрөнгө оруулалт. 13 тусгагдсан хөрөнгө оруулалтаас 9 хөрөнгө оруулалт нь боловсролын салбарт, 4 хөрөнгө оруулалт нь соёлын салбарт тусгагдсан буюу шинжлэх ухааны салбарт ямар нэг хөрөнгө оруулалт тусгагдаагүй байгаа юм. Харин 2021 оноос 2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн дүнд урт хугацааны хөрөнгө, хөтөлбөрт 2 хөтөлбөр, 2 хөрөнгө оруулалт туссан байгаад байгаа юм. Энэ нь Шинжлэх ухаан, инновацын төвийн кластер, нөгөөдөх нь Монгол Энэтхэг улсын хамтарсан мэдээлэл технологийн боловсрол болох аутсорсингийн төв гэдэг 2 хөрөнгө оруулалт тусаад явсан байгаа. Тэгэхээр эндээс юу хэлэх гээд байна гэхлээр 2012 онд батлагдсан төсөв, 2012 онд батлагдсан хууль Инновацын тухай хууль, Инновацын тухай

хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлага улсын төсвийн хөрөнгө оруулалт нь тухайн хууль батлагдсанаас хойш 9 жилийн дараа анх удаа тавигдаж эхэлсэн байгаад байгаа юм. Тэгэхлээр 2021 оноос хойш яг инновацтай холбоотой ийм улсын төсвийн хөрөнгө оруулалтууд хийгдээгүй байна гэж дүгнэж байгаа юм.

Мэдээж хуулийг яг бодит байдал дээр хэрэгжүүлэх хуулийн хэрэгжилтийг гол хангадаг зүйл хуулийг нарийвчлан зохицуулж байгаа журмын зохицуулалтууд байдаг. 2012 онд батлагдсан Инновацын тухай хууль дээр нарийвчлан ЗГ болон холбогдох асуудал эрхэлсэн сайдаар батлахаар нийт 11 журмыг хуульчилж өгсөн байна лээ. Тухайн 11 хуульчилж өгсөн журмын 9 журам нь тодорхой хэмжээнд батлагдсан, үндсэн 2 журам нь огт батлагдаагүй буюу 2012 оноос хойш хууль хэрэгжиж эхлээд 13 жил болж байхад 9 журам нь батлагдсан, 2 журам нь батлагдаагүй байна гэдэг дүгнэлтэд хүрч байгаа юм. Голлох журам, голлох журмууд нь болохоор 2020 болон 2023 онд батлагдсан байгаад байгаа юм. Тэгэхлээр энэ бас анхаарах ёстой зүйл байгаад байгаа юм. Яагаад гэхлээр хууль батлагдах үедээ тодорхой 3-аас 4 журмууд.../минут дуусав/

Ж.Золжаргал: 4 номерын микрофон нээж өгнө үү.

Б.Жавхлан: Хууль хэрэгжээд явж байх бол тодорхой журмууд нь батлагдаж байсан боловч голлох журмууд нь болохоор 2020, 2023 онд батлагдсан. Энэ нь яагаад ингэж батлагдаж байгаа вэ гэхлээр яг 2019 болон 20 ондоо тодорхой өөрчлөлтүүд бол хуульд нэмэлт, өөрчлөлт орсон учраас тэрэнтэй холбоотой журмууд нэлээн батлагдаад явсан байгаад байгаа юм. Тэгэхлээр одоо бол энэ батлагдаагүй 2 журам нь ямар журам байгаад байна гэхлээр Инновацын тухай хуулийн 7.3-д заасан инновацын үйл ажиллагааг төрөөс дэмжих хэлбэрийг өндөр технологи, инновацын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталсан журмаар зохицуулна гээд энэ тодорхой хэд хэдэн асуудлыг дурдчихсан байгаад байгаа юм. Яг энэ асуудлуудтай холбоотой журам нь өнөөдрийг хүртэл мөн батлагдаагүй. Мөн 17.1.4-д төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын лабораторийн тоног төхөөрөмжөөр инновацын үйл ажиллагааг дагнан эрхлэх компани хөнгөлөлттэй нөхцөлөөр үйлчилгээ үзүүлэх асуудлыг ЗГ журмаар баталж зохицуулна гэсэн боловч яг энэ журам нь батлагдаагүй байна гэж манай судалгааны багийн зүгээс үзсэн байгаад байгаа юм.

Инновацын ер нь төсөл хөтөлбөрийн санхүүжилт юмнуудыг нь ингээд харахаар санхүүжилт нь өөрөө Инновацын тухай хуулийнхаа 12.1 дэх хэсэг дээр тусгагдчихсан байгаад байгаа ямар эх үүсвэрүүдээс санхүүжих вэ гэдэг нь. Энэ дээр улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Монгол Улсын хөгжлийн банкны хөрөнгө оруулалт, Инновацын сангийн хөрөнгө. Гэхдээ Инновацын сангийн хөрөнгө нь 2015 оны хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хасагдчихсан байж байгаа. Тэгээд ЗГ-ын бусад тусгай сан, тэгээд хөрөнгө оруулалтын компанийн хөрөнгө, гарааны компанийн анхдагч зах зээлээс босгосон хөрөнгө, инновацад оролцогч талуудын өөрийн хөрөнгө, гадаад улс орнуудын байгууллагын зээл, тусламж, хуулиар хүлээгээгүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ гэж тодорхойлсон байгаа юм.

Тэгээд үндсэн 8 эх үүсвэрийг тодорхойлсон боловч яг Инновацын тухай хуультай хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа болон хуулийн хэрэгжилтийг хайгаад үзэхэд Шинжлэх ухаан, технологийн сангаас үндсэн Инновацын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой ихэнх төсөв санхүүжилт бол зөвхөн Шинжлэх ухаан, технологийн сангаас гарч байна гэж бид дүгнэсэн. 2021-ээс 2023 онд Шинжлэх ухаан, технологийн сангаас нийтдээ 941 судалгааны ажлыг санхүүжүүлж 22,6

тэрбум төгрөгийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. Үүнээс 2021 онд инновацын 16 төслийг санхүүжүүлсэн бөгөөд 1 санхүүжилтийн дүн нь 331,2 сая төгрөг, 2022 болон 2023 онд судалгаа төсөлд санхүүжилт хийгдээгүй. Тэгэхдээ 2022 онд 6 төсөл инновацын төсөл дээр грант олгосон буюу грант олгосон бөгөөд нийт санхүүжилтийн дүн нь 290 сая, 2023 онд 3 төсөл дээр грант олгосон 120 сая гээд. Тэгээд энэ дээр хэлэх гээд байгаа санаа нь юу вэ гэхлээр хууль дээр 8 төрлийн эх үүсвэрээс санхүүжнэ гэсэн байгаа боловч би өмнө нь хэлсэнчлэн хөрөнгө оруулалт, улсын төсөв хөрөнгө оруулалтаар тодорхой юмнууд юунууд санхүүжилт орж ирээгүй. Монгол Улсын хөгжлийн банкнаас олгосон зээлүүдийн мэдээллүүдийг санхүүжүүлж байгаа хөтөлбөрүүдийн мэдээллийг аваад үзэхэд тэнд өндөр технологи, инновацтай холбоотой төсөл хөтөлбөр байгаагүй. Тэгээд ЗГ-ын бусад сан гэдэг дээр болохоор яг энэ Шинжлэх ухаан, технологийн сангаас тухайн тодорхой инновацтай холбоотой юмнууд нь бол хэрэгжээд явж байсан байна гэж байна. Энэ Шинжлэх ухаан, технологийн сан нь өөрөө 2024 оны 4 сар хүртэл Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам дээр харьяалагдаад байдаг байсан. Одоо болохоороо шинэ яамныхаа бүтцээр Эдийн засаг, хөгжлийн яаман дээр харьяалагдаж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд ..., тэрний дараа нь дүгнэлтийг хийх юм байна.

Инновацын дэд бүтэц гэж байгаа юм. Инновацын дэд бүтэц дээр ямар асуудлууд байна вэ гэхлээр шинжлэх ухаан технологийн төвүүд болон паркууд дамжуулах төвүүд болон хамтын share office гэх мэт бүтэц бол дэд бүтцүүд хуульд тусгагдчихсан байгаа. Тэгээд инкубатор төвүүд гэж тусгагдсан байгаа юм. Сүүлийн 2 нь яагаад улаанаар тодруулж байна вэ гэхлээр энэ сая нөгөө улсын төсвийн хөрөнгө оруулалтаар энэ бол баригдаж байгаа том 2 төв байгаад байгаа. Тэгэхээр энэ 2 төв бол үндсэн хамгийн том ачааллыг авах нь гэж харж байгаа юм. Тэгээд энэ дээр дахиад хэлэх юмнууд нь болохоор Монгол Улсын шинжлэх ухааны паркийн захиргаа болохоор 2017 онд байгуулагдсан. Тус шинжлэх ухааны паркийн захиргаа нь болохоороо үндсэн юу, дамжуулах төвийн үүргийг бол технологи дамжуулах төвийн үүргийг бол гүйцэтгэж байгаа гэж үндсэн байгуулагдсан зорилго юмнаас нь харагдаж байгаа. 2023 онд яг энэ гарааны компаниуд, тэгээд энэ технологи дамжих төвүүд, хамтын оффисуудын бүртгэл Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам дээр хийгдээд, түүн бол дээр нийтдээ ийм 5 төв бол яг өөрсдөө бүртгүүлсэн байгаа. Энэ нь болохоор innovation hub буюу Нийслэлийн бизнес, инновац хөгжлийн газар, тэгээд Socratus startup studio, MStars hub, ... hub, тэгээд ШУТИС-ийн дэргэдэх Инновац, технологи дамжуулах төв гээд энэ газрууд бол ер нь бүртгэл хийлгэгчихсэн байгаад байгаа юм.

МУИС-ийн хажууд бол мэдээж Инновац, технологийг дамжуулах төв анх 2021 онд байгуулагдаж байсан. Гэхдээ энэ төв нь өөрөө 2023 онд Шинжлэх ухаан, технологийн паркийн харьяанд шилжээд, МУИС-ийн дэргэд байсан тухайн дамжуулах төв нь хаагдсан байж байгаа. Тэгэхлээр энэ дээр хэлэх гээд байгаа санаанууд нь болохоор их сургуулиуд дээрээ төвлөрсөн инновац, технологийг дамжуулах төвүүд, инкубаторууд нь байхгүй яг тусдаа бүтэц дээр байгаад байна гэдэг асуудлуудыг манай судалгаан дээр дурдсан байж байгаа.

Дараачийнх нь болохоороо Япон улсын хувьд ямар зохицуулалтууд шинэлэг зохицуулалтууд байна вэ гэхлээр ер нь бид нарын судалж үзсэн улсуудын зохицуулалт дээр ямар асуудал байна вэ гэхлээр Шинжлэх ухаан, технологийн тухай хууль гэдэг хууль байгаад байгаа юм. Тэр хуулиараа ер нь инновацынхаа тухай асуудлыг давхар зохицуулчихдаг буюу Монгол Улсад бол Шинжлэх ухаан, технологийн тухай хууль болон Инновацын тухай хуулиасаа 2 тусдаа хууль байгаад

байгаа. 2 тусдаа яам буюу сайд тухайн асуудлыг тусад нь эрхэлж байгаа. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль болохоороо Эдийн засаг, хөгжлийн яаман дээр харьяалагдаж байгаа шинэ бүтцээрээ бол тэрний асуудал бол. Харин инновацын асуудал бол, юун дээр байж байгаарай. Тийм Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаман дээр харьяалагдаад явж байгаа. Тэгэхээр энэ нь бусад улсуудтай харьцуулахад өвөрмөц тийм тогтолцоо байгаад байгаа юм. Яагаад гэхлээр инновац гэдэг нь өөрөө бусад улсууд юу гэж үзэж байна вэ гэхлээр шинжлэх ухааныхаа салбарын нэг дэд бүтэц гэж үзэж байгаа бол манай улсын хувьд хууль нь салангид, хариуцах юу нь, хариуцах этгээд нь салангид, холбогдох зүйлс нь салангид байгаад байгаа юм. Энэ бол нэг онцлог байна гэж харж байгаа юм.

Дараачийнх нь инновацын дэд бүтэц болох технологийн төв, парк, инкубатор төвүүд нь ихэвчлэн их, дээд сургуулийнхаа дэргэд байрлаж байгаа Япон улсын хувьд. Яг Япон улсын хувьд энэ инновацын хөтөлбөрийг яаж үндсэндээ хөгжүүлж дэмжиж байна гэхлээр их, дээд сургуулийнхаа дэргэд инкубатор төв, дамжуулах төвүүдийг байгуулаад, их, дээд сургууль дээрээ тухайн гарааны компани үүсгээд, хувийн компаниудтайгаа хамтарсан associate байгуулаад, тэр лүүгээ дараачийн хөрөнгө оруулалт руу шилжих юм руугаа явдаг буюу жишээ нь инновацыг хөгжүүлж байгаа гарааны компаниуд нь 90 хувь нь их, дээд сургуулийнхаа дэргэд байгаа инкубатор төвүүд, дамжуулах төвүүдээр дэмжиж гарч ирж байгаа. Тийм, тийм, тийм байдлаар. Тэр нь илүүтэй онцлог байж байгаа гэж харж байгаа юм. Тэгээд, мөн судалгаа хөгжүүлэлтийн нөгөө хуулийн этгээд буюу жижиг судалгааны төвүүд мөн ажилладаг байгаад байна. Тэр нь жишээ нь яаж байна вэ гэхлээр Японыхоо өөрөө өөрсдийнх нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэд Хавдрын судлалын төв, Эдийн засаг, хөгжлийн яамныхаа дэргэд Шинэ энерги судлалын төв ч юм уу иймэрхүү байдлаар төрийн захиргааны байгууллагууд ажилладаг.

Гэхдээ үндсэн инновацыг хэрэгжүүлдэг үндсэн инновацыг хөдөлгөдөг өөр инкубатор төвүүд нь их, дээд сургууль дээрээ түшиглэж ажилладаг. Их, дээд сургууль дээрээ байдаг. Их, дээд, жижиг, дунд бизнес эрхэлдэг бүлэг этгээдүүд тухайн шинэ технологитой холбоотой бизнес эрхлэхээр бизнестэй хамтарч ажиллах эсвэл бизнес эрхлэхээр бол их, дээд сургуулийнхаа инкубатор төвтэй хамтраад тэгээд явдаг байгаад байгаа юм. Тэгэхлээр ийм сонирхолтой бүтэц Япон улсын хувьд байна гэж харж байгаа юм. Шинжлэх ухааны паркийн үүргийг их, дээд сургуулиуд нь гүйцэтгэдэг гээд ер нь яг энэ дүгнэлт байдлаар ингээд л биччихсэн байж байна.

Дараачийнх нь болохоор мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улс бол яаж байна гэхлээр Шинжлэх ухаан, технологийг дэмжих тухай хууль гээд тусдаа Инновацын тухай хуультай улс ер нь байхгүй. Бидний судалсан хүрээнд гарч ирээгүй. Яг Шинжлэх ухааныхаа хуулиар зохицуулаад явчихдаг. Тухайн юу нь төсөв мөнгө нь яг тэндээсээ гараад тэгээд хэрэгжүүлэх этгээд нь ч гэсэн яг адилхан байгаад явчихдаг байгаад байгаа юм. Шинжлэх ухаан, технологийн санхүүжилтийн тэргүүлэх чиглэлийг БНХАУ хамгийн эхэнд баталдаг юм байна лээ. Түүн дээр юу гэж баталж байна вэ гэхлээр суурь судалгаа, салбар дундын судалгаа, үйлдвэрлэлд өндөр технологи ашиглах. Хамгийн гол жишээ нь бусдаас ялгарч байгаа зүйл нь юу вэ гэхлээр шууд үйлдвэрлэлд өндөр технологийг хэрхэн ашиглах вэ гэдгээр БНХАУ тэрэндээ маш их ач холбогдол өгдөг гэж харагдсан.

Дараа нь экологи, хүний эрүүл мэнд, дараа нь шинжлэх ухааны боловсон хүчнийг бэлтгэх, шинжлэх ухааныг олон нийтэд таниулах гэдэг үндсэн чиглэлүүдийнхээ хүрээнд санхүүжилтийг тэргүүлэх чиглэлээр олгоод явдаг байгаад

байгаа юм. Төрөөс үзүүлж буй санхүүгийн дэмжлэгүүд нь үйлчилгээнүүд нь ямар үйлчилгээнүүд байна вэ гэхлээр суурь судалгааг дэмжих сан гэж байдаг тусдаа сан, жижиг, дунд компанийг дэмжих сан гэж байдаг. Тэгээд шинжлэх ухааны салбарт давуу зээл олгох буюу шинжлэх ухааны тодорхой инновацтай, инновац шингээсэн, үндэсний инновацыг шингээсэн бүтээгдэхүүнүүдэд давуу байдалтай зээл олгодог. Мөн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлдэг. Монгол Улсад өнөөдрийн байдлаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг гарааны компани, тодорхой инкубатор төвүүд дээр үзүүлж байгаа. Мөн хамгийн их Инновацын тухай хуулиар хийгдэж байгаа зүйл бол инновацтай холбоотой грант тэтгэлэг зүйлүүд л ер нь үндсэндээ Инновацын тухай хуулиар өнөөдөр олгогдож байгаа гэж харж байгаа.

Тэгээд Хятад улсын давуу тал нь гэх нь үйлдвэр, үйлдвэрлэл, компаниудыг дэмжих хандлагатай байдаг. Үйлдвэрлэл компаниуд нь шинэ инновац, шинэ технологи гаргавал тэн дээрээ зээл, тусламжаа олгоод явчихдаг буюу Япон улсыг бодвол их, дээд сургууль түшиглэхээсээ илүүтэй үйлдвэр болон жижиг, дунд үйлдвэрлэлүүд компаниуд руугаа илүү түшиглээд инновацынх нь төсөл хөтөлбөрүүд нь тийшээгээ илүү чиглэсэн байдлаар хэрэгжээд явдаг гэсэн үг. Тэгээд энийгээ яаж байна вэ гэхлээр нөгөө технологио бизнестэй холбож байгаа л юу, бизнес нь өөрөө өсөх хүслээ, өсөх эрмэлзэл байгаа болохоор технологио заавал хөгжүүлнэ гэдэг л тийм агуулгаар ингээд холбоод явчихсан байгаад байгаа юм.

Тэгээд нэгдсэн байдлаар харьцуулсан судалгааны дүгнэлт юу гэж гарч байна вэ гэхлээр Инновацын тухай хууль болон Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн зохицуулалт нь нэг хуулиар зохицуулагддаг харилцаа байна. Ер нь уялдаа холбоог нь хангах шаардлагатай байна. Одоо байгаа Инновацын тухай хуулийг шууд хүчингүй болгоод явах нь зүйтэй биш. Ямар нэгэн байдлаар 2024 оны 5 сард батлагдсан Шинжлэх ухааны тухай хуультай холбогдуулаад уялдаа холбоог нь маш сайн хангах шаардлагатай байна гэдэг дүгнэлтэд хүрч байгаа. Мөн хуулийн хэрэгжилтийг их, дээд сургуулиудаар дамжуулан хэрэгжүүлдэг эсвэл компаниудаар дамжуулан хэрэгжүүлэх гэсэн үндсэн 2 аргачлал бидний судалгааны хүрээнд ингээд тусгагдсан байгаад байгаа юм. Тэгэхлээр эндээс тодорхой Инновацын тухай хуулийнхаа үзэл баримтлал юман дээр тодорхой оруулах юмнууд нь орж ирэх байх л гэж харж байна.

Үндсэн шууд товчхондоо дүгнэлт хэсэг рүүгээ орчихъё. Дүгнэлт хэсэг дээр Инновацын тухай хуулийг хангалтгүй хэрэгжиж байна гэж бид дүгнэсэн. Жишээ аваад үзвэл Инновацын мэдээллийн сан гэдэг зүйл байгуулагдах ёстой. Даанч Инновацын мэдээллийн сан гэдэг зүйл хууль батлагдсанаас хойш огт байхгүй гэх мэтчилэн бусад ингээд дүгнэлт юмнууд нь судалгаа дээр нарийвчлаад байж байгаа. Та бүхэн маань ингээд танилцаж болно. Тэгэхлээр бид яаж байна вэ гэхлээр Хууль тогтоомжийн тухай хуульд заасныхаа дагуу судалгааны дүгнэлт дээр хуульд агуулгын шинжтэй нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай байна гэдэг дүгнэлтийг гаргаж байгаа. Тэгээд Инновацын тухай хуулийн хүрээнд мөрдөгдөх дунд болон богино хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөг батлах шаардлагатай байна. Яагаад гэхлээр 2011 оны 10 сараас хойш энэ дунд хугацааны бодлого, төлөвлөлт, хөтөлбөрүүд огт батлагдаагүй. Энийг яаралтай асуудал эрхэлсэн бодлого, бодлогын асуудал эрхэлсэн газрууд нь батлаад явах зайлшгүй шаардлагатай байна гэж харж байгаа.

Урт хугацааны төлөвлөгөө бид нарт байж байгаа 2050 төлөвлөгөө маань байж байгаа. Дунд хугацааныхаа төлөвлөгөөг бид батлаад явах зайлшгүй шаардлагатай байна гэж харж байгаа юм. Энэ дээр бид нар дээр байгаа юм нь,

тэгээд хуулийн хэрэгжилтийг хангах этгээдийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна гэж байгаа юм. Энэ дээр яаж байна вэ гэхлээр сая миний хэлсэнчлэн нөгөө 2 яамны яг инновац гэдэг нь өөрөө шинжлэх ухааны нэг дэд салбар гээд явах юм уу эсвэл ингээд тус тусдаа явах юм уу гэдгээ яг ингээд тодорхой болгохгүй бол жишээ нь энэ инновац үндэсний юуг болохоор үндэсний инновац энэ өндөр технологийн асуудлыг болохоор 2021 оноос өмнө юу нь шинжлэх ухаан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам бол хариуцдаг байсан 2021 оноос хойш шинэ яам руугаа ингээд шилжчихсэн байгаад байгаа. Тэгээд тэрэнтэй холбоотой яг хэрэгжүүлэх этгээдийг нь тодорхой болгоод, яг юу, юу Шинжлэх ухаан, технологийн тухай хууль дээр зааснаас бусдаар яг юу юу нь инновацтай хамаарах юм, яг юу нь тодорхой байх юм гэдгийг нарийвчлан тогтоох шаардлагатай байна гэж харж байгаа юм.

Тэгээд санхүүжилтийн, тэгээд хамгийн сүүлчийн дүгнэлт. Санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тодорхойлох шаардлагатай байна гэж байгаа юм. Энэ дээр яагаад ийм дүгнэлтэд хүрч байгаа вэ гэхлээр товчхондоо Инновацийн тухай хуулийг ингээд бүхэлд нь хараад үзвэл юу хийгдэж байна вэ гэхлээр яг энэ инновац, цахим инновацтай холбоотой Инновацийн тухай хуультай холбоотой зардлуудын 70 хувь нь буюу урсгал зардал байгаад байгаа юм. Би өмнө хэлж байсан тийм ээ, 70 хувь нь урсгал зардал, үлдсэн 30 хувь нь болохоороо судалгаа, тэтгэлэг, төслүүд дээр олгогдож байгаа. Судалгаа, тэтгэлэг, төслүүд дээр олгогдож байгаа тэр нөгөө 30 хувийн хөрөнгө оруулалт нь өөрөө Шинжлэх ухаан, технологийн сангаас гарч байгаа. Тэр сан нь өөрөө боловсрол, үгүй ээ юуны сүүлд юу яаснаар Эдийн засаг, хөгжлийн яаман дээр харьяалагдаж байгаа учраас Инновацийн тухай хуулийг хэрэгжүүлэх этгээд нь өөрөө Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам боловч яг энэ шинжлэх ухааны сангаар дамжуулж санхүүжилтийг нь гаргаж байгаа нь өөрөө Эдийн засаг, хөгжлийн яам байгаад байна. Тэгэхлээр энийг бас тодорхой болгох хэрэгтэй байх гэж харж байгаа.

Мөн Шинжлэх ухааны паркт технологи дамжуулах, тэгээд хамтын оффисуудын татварын хөнгөлөлт тодорхой хэмжээнд хэрэгжээд явж байгаа гэж бид дүгнэсэн. Тэгээд бүхэлд нь хуулиа харвал манай хууль маань жоохон бүдүүлгээр хэлбэл зөвхөн грант тэтгэлэг олгодог л ийм хууль болчихсон байна гэж дүгнэж байгаа юм. Ингээд миний танилцуулга дууслаа. Та бүхнээс асуулт байвал хариулъя.

Ж.Золжаргал: Баярлалаа асуулт хариулт руу орохоосоо өмнө 2 юугаа Эдийн засгийн яам болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төлөөллөөс та бүхэн 4, 4 минутаар энэ ерөнхий байр сууриа нэг илэрхийлээч гэж хүсэж байна. Ер нь хуулийн хэрэгжилт хангалтгүй шалтгаанууд нь ийм байна гээд хэллээ, түүн дээр санал нийлж байна уу, ямархуу бодолтой байна вэ гээд тэгж байгаад асуулт хариултдаа оръё. 2 яамнаас гадна Шинжлэх ухаан, технологи, инновацын үндэсний хороо гээд байгууллагатай болчихсон байгаа. Тэгэхээр ингээд 3 субъект байна. Тэгэхээр ямар ч байсан яамны 2 төлөөлөл энэ хэрэгжилт дээр ямар дүгнэлт өгч байгаа вэ гэдгээ 4 минутад багтаагаад хэлж өгнө үү. 6 номер. Баттогтох дарга өөрийгөө танилцуулаад эхэлчихье. 6 номерын микрофон нээж өгнө үү.

Д.Баттогтох: Байнгын хорооны дарга гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Эдийн засаг, хөгжлийн яам Шинжлэх ухааны технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Баттогтох. Тэгэхээр үнэлгээ хийсэн баг болоод үнэлгээний дүгнэлттэй ерөнхийдөө санал нэг байна. Ер нь нэмээд хэлэхэд яах вэ дотор нь ингээд нарийвчлаад харвал олон асуудлыг бүр дэлгэрэнгүй ярьж, учир шалтгааныг нь тайлбарлах бололцоотой байх. Гол асуудал бол 2024 онд Шинжлэх ухаан,

технологийн хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаар баталсан. Тэгээд тэр найруулга маань ер нь 18 жилийн дараа үндсэндээ яг энэ саяын шинжээчийн багийн дүгнэлттэй нийцсэн. Энэ шинжлэх ухаан, технологи, инновац гэдгийг нэг эко систем байхаар харж хуульчилсан байгаа. Тэгэхээр хуулийн хамрах хүрээ бол тэр агуулгаараа нэлээн өргөн болсон.

Өөрөөр хэлбэл хувийн хэвшил болоод аж үйлдвэрийн салбарыг энэ шинжлэх ухаан, технологи, инновацын эко системдээ оролцуулж хуульчилснаараа их онцлог болсон. Тэгээд тэр агуулга талаасаа зөвхөн төрийн санхүүжилт биш, хувийн хэвшлийн үйлдвэрлэлийн санхүүжилтийг татах тийм зохицуулалт механизмууд орсон байгаа. Харамсалтай нь Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хууль сая бас шинжээчдийн дүгнэлтээр гарч байна. Инновацын асуудал Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам руу, шинжлэх ухаан, технологи нь Эдийн засаг, хөгжлийн яам дээр ирсэн. Угтаа бол Эдийн засгийн хөгжлийн яам дээр яг шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлого буюу шинжлэх ухаан, технологи, инновацыг тэр аж үйлдвэр бусад эдийн засгийн салбаруудтай интеграци хийх бололцоо нь уг нь олдсон. Тэрийг яг хийдэг механизм нь бол энэ инновацын тогтолцоо байгаа. Гэтэл инновацын тогтолцооны бодлого, хөгжүүлэлтийн асуудал нь Цахим хөгжлийн яаман дээр оччихсон. Тэгээд яг манай инновацын тэргүүлэх Монгол Улсын 6 чиглэлийн үндсэндээ нэг л чиглэл дээр анхаарч ингэж яваад байгаа юм. Тэгэхээр энэ бол шинжээчдийн саналтай санал нэг байна гэж харж байна.

Тэгээд мөн яг энэ Инновацын тухай хуулийг шинэчилж найруулах шаардлага байгаа. Яагаад гэхээр сая бол 11 журам гэж байна. Яг бид ингээд нарийвчлаад хуулийн зохицуулалтаа харвал салбарын сайд болоод ЗГ-аар орох 23 журам гарах ёстой. Журам шийдвэрүүд. Түүнтэй холбоотой үндсэндээ одоо 11-ийг нь баталчихсан байгаа. Үлдсэн хэсгийг нь яагаад батлахгүй байна гэхээр дагалдах хуулиуд дээр зохицуулалтууд нь тусгаж өгөөгүй учраас тэр журмуудыг гаргах дээр Сангийн яамнаас юм уу, аль нэг яамнуудаас энэ хуультай зөрчилдөж байна гэсэн ийм сөрөг саналууд ирчихдэг учраас ингээд журмууд нь гарахгүй, гараад ч бусад хуулиудтайгаа зөрчилдөх учраас хэрэгжих боломжгүй тийм тохиолдлууд байгаа. Тухайлбал тэр худалдан авалттай холбоотой заалт байна. Мөн орон нутгийн санхүүжилт бол энэ инновацыг дэмжих нэг эх үүсвэр. Тэд нартай холбоотой зохицуулалт хийх журмыг ЗГ-аар батлуулах дээр орон нутгийн нэгжийн тэр эрх зүйн зохицуулалт дээр нь тусаагүй байж байдаг гэх мэтчилэн ийм хуулийн үйлчлэх хүрээ дагалдах хуулиудтайгаа зөрчилдсөн учраас ийм асуудлууд үүсээд байгаа.

Ер нь санхүүжилт хангалтгүй гэдгийг шинжээчдийн багтай санал нэг байна. Үндсэндээ бараг 1 тэрбумаас 1 тэрбум 500 төгрөг сүүлийн 10 жилд яг энэ өндөр технологи инновацын чиглэлд зарцуулж байгаа. Тэрэндээ яах вэ инновацын грантаар тодорхой хэсгийг нь, тэгээд энэ түгээн дэлгэрүүлэлт инновацын соёлыг бий болгох чиглэлээр тодорхой зардлууд явдаг. Тэгэхээр энэ тоо бол олон улстай харьцуулахад үзэгдэл төдий тоо. Тэгэхээр энэ боломжгүй. Бусад эх үүсвэрээ нэмэгдүүлэх талын зохицуулалтууд хэрэгтэй. Энэ Шинжлэх ухаан, технологийн сангаас гол санхүүжилтийн дэмжлэг гарч байгаа. Бусад тэр түгээн дэлгэрүүлэлт, тэр патентжуулах гээд гол, гол зардлуудыг гаргах дээр Тусгай сангийн хуультайгаа зөрчилдчихдөг. Тэгэхээр энэ Шинжлэх ухаан, технологийн сангаа эсхүл Шинжлэх ухаан, технологи, инновацын сан болгож өргөжүүлэх, эсхүл Инновацын санг анх.../минут дуусав/

Ж.Золжаргал: Юуны Бат-Өлзий дарга 1 номерын микрофон нээж өгнө үү.

Б.Бат-Өлзий: Сайн байцгаана уу, эрхэм Байнгын хорооны гишүүд, Байнгын хорооны дарга та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим шилжилтийн бодлогын хэрэгжилт, зохицуулалтын газрын дарга Бат-Өлзий байна. Манай яаман дээр инновацын бодлого албан ёсоор шилжиж ирээд өндөр технологи, инновацыг хөгжүүлэх гэдгээр албан ёсоор ЗГ-ын шинэ бүтцээр орж ирсэн байгаа. Түүн дээр батлагдсанаас хойш манай албан ёсоор бүтэц яг инновацын газар Төрийн албаны зөвлөлөөс батлагдаад яг 3 сарын 12-нд албан ёсоор 25 оны 3 сарын 12-нд албан ёсоор яг ажиллаж эхэлж байгаа. Гэсэн хэдий ч ер нь инновацын талаар дэмжлэг үзүүлэх олон төрлийн ажлуудыг хийж байгаа.

Инновацын яг дэмжлэг start up компаниудыг ер нь дэмжих гэдгээрээ манайх салбарт IT парк үндэсний, Мэдээлэл технологийн үндэсний парк харьяалагддагийн хүрээнд бид гарааны компани start up компаниудыг дэмжих зорилгоор олон төрлийн ажлуудыг хийдэг. Ер нь start up компаниудыг дэмжих зорилгоор ер нь 10 төрлийн дэмжлэг бид хийнэ гэж энэ жилийн төлөвлөгөөнд ороод явж байгаа. Манай яг яамны инновацын чиглэлээр 1,4 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан байгаа. Төсвийн хүрээнд бид инновацын яг оролцогч байгууллагуудыг компаниудыг инкубатор дэмжлэг 1 дүгээрт, мөн дэд бүтцээр дэмжих, коммунити хөгжүүлэлт тал дээр нь илүү олон төрлийн мэдлэг туршлагаа хуваалцах дээр нь дэмжих зорилгоор ажиллаж байгаа. Мөн зах зээлд нэвтрэхэд нь олон улсын silicon valley гэх мэт байгууллагууд дээр холбох хамтран ажиллах байдлаар дэмжлэг үзүүлж байгаа. Мөн сургалтуудыг олон төрлөөр зохион байгуулж байгаа. Энэ жилээс инновацын яг компаниудад хэрэгтэй дараагийн технологиуддаа нэвтрүүлэхэд нь хэрэгтэй судалгаа хөгжүүлэлтүүдийг хамтран ажиллахаар төлөвлөөд ажиллаж байна. Мөн мэдээж төрийн худалдан авалтаар start up компаниудаасаа гаргаж байгаа бүтээгдэхүүнүүдийг энэ Монголынхоо start up-г илүү дэмжье гэсэн ийм бодлогыг гаргахаар ингээд ажиллаж байгаа.

Татварын урамшуулал, татвар дэмжлэг гэдэг дээр бид энэ сүүлийн хугацаанд coworking space-үүд олноор Монгол Улсад байгуулагдсан боловч ямар нэгэн coworking space-ийг яг дэмжсэн дэмжлэг байхгүйгээс болоод одоо бол арваад байх ёстой бол одоо дөнгөж хоёрхон байж байгаа яг хувийн хэвшлээс бол. Төрийн байгууллагад төрд инновацын hub байсан бол одоо хаагдчихсан байж байгаа. Тэгэхээр ер нь төрөөс гол дэмжлэг хамгийн чухал бол дэд бүтцээр дэмжих. Тэгээд мэдээж татвар дэмжлэгээр дэмжих гэж байгаа. Тэгэхээр энэ дээр дэд бүтэц гэдэг дээр барилга байгууламжаар start up компани ер нь байгуулахаас нь өмнө яг коммунити байдлаар хөгжихөд нь тусалсан энэ coworking space-ийг ер нь олноор байгуулах тал дээр coworking байгуулж байгаа байгууллагууд дээр нь татварын дэмжлэг үзүүлэх ч гэдэг юм уу энэ талаас нь дэмжих ёстой юм байна гэсэн том зургаар нь хараад ингээд манай яамнаас ажиллаж байгаа. Тэгээд яг өнөөдрийн тэр сая 2 өнцөгтэй юм яриад байна. Яах вэ хуулийн талаар ярьж байгаа, бас ЗГ-ын яг бүтцийн асуудал бид нарын юунаас эрх хэмжээнээс өөр асуудал байх. Бид яг хуулийн хэмжээнд мэдээж бүрэн хэрэгжсэн гэж үзэхгүй байгаатай би санал нийлж байгаа. Гэхдээ энэ дээр бид тухайлсан санхүүжилтийг шийдээд явбал мэдээж инновацын юу бол дэмжих, хөгжих боломжтой гэж үзэж байгаа. Баярлалаа.

Ж.Золжаргал: Үйл ажиллагааны танилцуулга хийлээ. Асуулт хариултдаа оръё. Тэгээд би зүгээр нэг зүйл хэлэхэд шинжлэх ухаан, технологи, инновац, инновацын бодлого гээд их сургуулиудаа дагаж явдаг ерөнхий жишиг байдаг Боловсролын яам, эдийн засагжуулна, инновацыг эдийн засагжуулна гээд Эдийн засаг, хөгжлийн яам руу шилжсэн. Тэгэхдээ инновацтайгаа ойрхон нь Цахим хөгжил,

инновац, харилцааны холбооны яам юм гээд ингээд 3 хэсэг байгаа. Тэгэхээр энийг өнгөрсөн Засгийн бүтцийг анх зурж байхад л чуулган дээр яригдаад явсан сэдэв. Яг Инновацын хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээг сонсохтой шууд хамаатай биш, гэхдээ яг ингээд нөгөө хуулиа хэрэгжүүлэхэд нөлөөлөх нь тодорхой учраас мэдээж энэ талаар санаа бодлоо илэрхийлэх нь чөлөөтэй байх. Ер нь зүгээр асуудал маань Инновацын тухай хуулийн хэрэгжилт гэдгийг нэг сануулж хэлье гэж бодож байна.

Асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Дарчих, урдхаа дарчих та. Асуулт авах гишүүд нэрсээ өглөө. Пунсалмаа гишүүн, Ганбаатар, Цэнгүүн, Рэгдэл гишүүн байгаа. Рэгдэл гишүүний юу нь орж өгөхгүй байна, оруулаад өгчхөөрэй, орох ёстой, хуруугаа уншуулсан юм уу та? Рэгдэл гишүүнийг нэмж өгөөрэй, тэгээд Золжаргал. Ингээд дарааллаар Пунсалмаа гишүүн асуултаа асууна уу.

Б.Пунсалмаа: Энэ өдрийн амар амгаланг айлтгая. Өнөөдөр Монгол Улс энэ инновацлаг байдлаараа дэлхийн 132 орны 68-д орж байгаа. Энэ тоо ерөөсөө 4 жилийн өмнө 58 байсан юм байна. Дөрөвхөн жилийн дотор 10 байраар ухралт хийсэн байна инновац дээр. Гэтэл бид Инновацын төслийн тухай хууль дээр инновац оруулсан компаниудад төсвөөс санхүүжилт хийнэ, грант гаргана, гадаадын зээл авбал баталгаа гаргаж өгнө, үнэт цаас гаргаж өгнө гээд тэгчихсэн байгаа. Тэгэхлээр яг энэ дэмжлэг туслалцаа грант авчихсан, ЗГ-ын баталгаа гаргачихсан ямар, ямар хамгийн томоохон инновац шингэсэн энэ төрийн дэмжлэг авсан компаниуд байна нэрлэж болох уу? Эдгээр компаниудыг төрийн зүгээс дэмжиж байгаа гэж байна. Энэ төрийн худалдан авалтаар яаж дэмжиж байгаа юм бэ? Нэгэнт л хөрөнгө оруулалт хийсэн юм бол биднийг бүх шатад нь дэмжээд энэ компанийг олон улсад хүртэл нь дэмжих ёстой энэ дэмжлэгүүдийг нэг сонсьё гэж бодож байна.

2 дугаарт энэ олон байр ингэж ухарч байгаагийн нэг гол шалтгаан нь болохлоор ер нь инновац өөрөө энэ high болон med технологийн үйлдвэрлэл манай Монголд хөгжөөгүй байгаа. Гадаадын хөрөнгө оруулалт сайн хөгжөөгүй байгаатай холбогдуулаад энэ олон улсын технологиуд сайн орж ирээгүй байгаа. Үүнээс болоод магадгүй энэ инновац өнөөдөр тийм өндөр түвшинд хүрэхгүй байна гэж ойлгож болно. Гэтэл үүний хажуу талд болохлоор инновацын кластер хөгжил гэж юм байгаа. Кластер хөгжил дээр манай энэ хөрш орон хамгийн сайн хөгжүүлж байгаа. Энэ кластер хөгжил гэхлээр ерөөсөө 1 инновацын салбараа барьж аваад тэр салбарт орж ажилладаг салбаруудыг бүгдийг нь нэг цонхонд бөөгнүүлээд, тэдгээр хоорондоо уулзах, бие биедээ дэмжлэг үзүүлэх энэ бололцоог нь хангах, дээрээс нь энэ эрдэм шинжилгээний байгууллагуудтай оюутан бэлтгүүлэх, боловсон хүчин бэлтгүүлэх, олон улс, олон жилийн суурь судалгаа хийлгүүлэх ийм эрдэм шинжилгээнийхээ байгууллагуудтай хамтарч ажиллах, мөн тухайн салбарууд өөрсдөө ямар инновац шингэсэн бүтээгдэхүүн бидэнд хэрэгтэй байгаагаа хоорондоо уулзаж энэ гаргалгаагаа гаргаж авах ийм кластер хөгжлүүд байгаа. Энэ кластер хөгжлийг ер нь бий болгох тал дээр яаж ажиллаж байгаа вэ? Ийм 2 асуулт.

Ж.Золжаргал: Судалгаа хийсэн байгууллагатай холбоотой болон засагтай холбоотой асуудлууд байгаа учраас та бүхэн өөрсдөө гараа өргөөд хариулчих уу? Баттогтох дарга 6 номерын микрофонд.

Д.Баттогтох: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ер нь инновацын энэ индекс ухарч байгаа. Одоо бол 2024 он, ухарч байгаа гол шалгуур үзүүлэлт нь сул талууд нь 1 дүгээрт инновацын холболт гээд сая таны дурдсан энэ кластер болж ажиллах энэ үзүүлэлт бараг 132-оос 110-д эрэмбэлэгдэж байгаа. Мэдлэгийн нөлөө гээд мэдлэгийн яг мэдлэгт суурилсан бизнес эрхэлж байгаа тэр

бүтэц үндсэндээ 116-д, судалгаа хөгжүүлэлтийн зардал өөрөө шинжлэх ухаан, технологид оруулж байгаа зардал нь өөрөө 94 дээр эрэмбэлэгдэж байгаа гэх мэтчилэн энэ үзүүлэлтүүд нэлээн хойш нь татаж байгаа. Тэгэхдээ энэ үзүүлэлт харилцан ингэж динамик байдлаар өөрчлөгдөөд байгаа. Тухайлбал 23 онд 69 байсан бол 24 онд 67 дугаар байранд орж ингэж урагшилсан ийм үзүүлэлттэй байгаа юм. Тэгэхээр гол сулруулж байгаа үзүүлэлт саяын дурдсан ийм үзүүлэлт байгаа.

Нэмээд энэ үзүүлэлт дээр тэр аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадварын үзүүлэлт өөрөө 132 орноос 100 дээр эрэмбэлэгдэж байгаа. Өөрөөр хэлбэл мэдлэг технологи шингээж үйлдвэрлэл эрхлэх тэр үйлдвэрлэлүүд нэлээн сул байна гэж харагдаж байгаа юм. Юуны тухайд ер нь яг энэ Инновацийн тухай хууль нэг дутагдалтай тал нь илүү зөвхөн гарааны компаниудын инновацыг хөгжүүлэх тэр тал руугаа илүү чиглэгдэж дэмжлэгүүд нь хуульчлагдсан байдаг. Томоохон компаниуд өөрөө инновацын үйл ажиллагаа эрхлэх тийм сонирхлууд байгаа. Тэрийг зохицуулсан зохицуулалт харьцангуй дутмаг байна гэж харж байгаа. Сая таны дурдсан олон нийтэд хувьцаа санал болгох журмыг Санхүүгийн зохицуулах хорооноос 2020 оны 995 дугаар тогтоол, 18 оны 353 дугаар тогтоолоор баталсан байгаа. Яг гарааны компаниудын тухайд томоохон ийм жишээ болгох зүйлүүд одоохондоо гараагүй байгаа.

Тэр кластерыг хөгжүүлэх дээр бид ер нь энийг яг бүтцийн хувьд ямар хэлбэрт хөгжүүлэх вэ гэдэг дээр бид нэлээн бодлогоо чиглүүлж, түүнд зохицсон тэр дэд бүтцийг нь хөгжүүлэх шаардлагатай гэж харж байгаа. Өөрөөр хэлбэл их сургуулиудын дэргэд технологи дамжуулах төвүүд, хувийн хөрөнгө оруулалтын дэргэд хамтын оффисууд, үйлдвэрлэлүүдийн хүрээнд үйлдвэрлэл, судалгаа хөгжүүлэлтийн байгууллагын хүрээнд шинжлэх ухааны паркийг хөгжүүлж чадвал тэнд нөгөө олон оролцогчид буюу үйлдвэрлэгчид, судалгаа, хөгжүүлэлтийн байгууллагууд, технологийн үнэлгээ хийдэг байгууллагууд, тусгай сангууд, хөрөнгө оруулалтын сангууд гээд нэг дор газар зүйн байрлалын хувьд хамтарч ажиллаад ингээд нэмүү өртөг бий болгох ийм бололцоотой байна гэж харж байгаа юм. Тэгэхээр энэ рүү чиглэсэн Шинжлэх ухааны паркийн хууль бол Инновацийн тухай хуульд нэг бүлгээр зохицуулагдаж явдаг. Тэгэхээр энийг бүүр тусгайлсан анхдагч хуулиар.../минут дуусав/

Ж.Золжаргал: Ганбаатар гишүүний асуултыг авъя.

А.Ганбаатар: Энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд хожуу ч гэсэн манай судалгааны байгууллага судалгаа хийгээд гаргаж ирж байгаа нь сайшаалтай байна гээд. Энэ Парламентын хөгжлийн судалгаа, хөгжлийн төв захиалга өгөхөөр цаашаа дамжуулаад нөгөө Дөлгөөн цагаан компанид өгчхөж байгаа юм байна шүү дээ тийм үү? Давхар түрээс гэдэг шиг. Тэгээд хийсэн газар нь Дөлгөөн цагаан юм байна.

Яах вэ оршил болгоод хэлэхэд энэ намар ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр хэлэлцэж байх үед байр сууриа илэрхийлж байсан юм. Өөрөөр хэлбэл шинжлэх ухаан, инновац 2 чинь салаад явчихлаа, 2 яамны бодлогоор зөрөөд. Гэтэл нөгөө ажиллах салбар хөгжүүлэх салбар нь гэдэг юм уу тэр Пунсалмаа гишүүний хэлж байгаа кластерууд хөгжүүлэх салбар нэг байгаад байдаг. Тэгээд сиамын ихэр шиг болж байна шүү гэдэг саналаа хэлж байсан. Тэгээд яг өнөөдөр энэ хуулийн дүгнэлтийг харж байхад дахиад шинээр хууль боловсруулах түвшинд болчихсон юм байна гэж харагдаж байна л даа. Энэ судалгааны байгууллагаас асууж байгаа нь болохоор энэ Хууль тогтоомжийн тухай хуулийн 53, түүний дотор 53.1-д байна уу

даа 5 жил тутам хууль бүрд хэрэгжиж эхэлснээс хойш 5 жил тутамд үнэлгээ шинжилгээ хийнэ гэсэн байна лээ. Тэгээд одоо энэ чинь 12 оноос хойш гэхээр ингээд 13 жил ямар ч үнэлгээ шинжилгээ байхгүй. Энэ анх удаагийн шахуу ийм дүгнэлт болж байгаа байхгүй юу. Тэгээд энийг өмнөх байгууллагуудаасаа та нарыг гэж хэлээгүй, өмнөх байгууллагуудаасаа тодруулсан уу, захиалга авч байсан юм уу, аваагүй юм уу? Хэрвээ 2-оос 3 удаа энд хийчихсэн байсан бол хуульдаа шинэчлэл хийх дараа дараачийн алхмуудаа олоод харахад их нэмэртэй байсан гээд түүнийг тодруулж өгөөч гээд.

2 дахь асуулт нь болохоор энэ үнэлэгдэх хэсгийг тогтоохдоо 2 зүйлийн тухайлбал 2 дугаар бүлэг, 3 дугаар бүлгийн, 2 дугаар бүлгийн дотор 6 дугаар зүйл 12, 3 дугаар бүлгийн 16 гээд 2 бүлгийн 3 зүйлийг хамруулаад судалгаа хийчихсэн юм шиг харагдаад байна л даа. Баасандорж даргын газраас өгсөн захиалгыг нь харахад энэ хуульд бүтэн судалгаа хийгээд танилцуулаач гэсэн ийм агуулга харагдаад байгаа юм. Тэгээд үүнийг нэг тайлбарлаж өгөөч гээд ийм 2 асуулт байгаа юм.

Ж.Золжаргал: 3 номерын микрофон нээж өгнө үү.

Д.Онолт: Гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд өнгөрсөн оны 11 дүгээр сард манай Судалгаа, хөгжлийн хүрээлэнд Инновацийн тухай хуульд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийлгэх судалгааны захиалга ирсэн. Энэ судалгааны захиалгатай холбоотой он дуусах гээд ерөнхийдөө нэлээн хугацаа шахагдсантай холбоотойгоор яаралтай судалгааны ажлын даалгавар гаргаад энэ чиглэлээр ажиллаж байсан, өмнө нь ажиллаж байсан хүмүүстэй холбогдсон. Энэ хүрээнд өмнөх хийсэн судалгааны энэ хэрэгжилтийн үр дагаврын судалгаатай холбоотой асуудлыг Боловсролын яамтай холбогдож мэдээллүүдийг цуглуулсан. Үүнтэй холбоотойгоор цуглуулсан мэдээллийг судалгаа гүйцэтгэгчтэй холбогдоод тухайн үед танилцуулсан. Яг хэрэгжилтийн үр дагаврын бүрэн үнэлгээ байгаагүй. Бидний зүгээс ажлын даалгаврыг ерөнхий агуулгаар хэрэгжилтийн үр дагавар гэдэг хэлбэрээрээ яваад, судалгааны судлах, судалгааны хамрах хүрээг захиалагч буюу Их Хурлын Тамгын газрын холбогдох албан хаагчидтай тохиролцоод Дөлгөөн цагаан интернэйшнл компанитай энэ ажлын даалгаврын хүрээнд гэрээ байгуулсны дараа бол тохиролцоод энэ ажлын даалгаврыг аваад, тайлангаа эхний байдлаар хүлээж аваад, Их Хурлын Тамгын газрынхандаа танилцуулаад ингээд ажлыг хүлээж авсан байгаа.

Ж.Золжаргал: 4 номер.

Б.Жавхлан: Инновацийн тухай хуультай холбоотой холбогдох яамнууд нь тухайн нөгөө жилийнхээ төлөвлөгөө дээр л үнэлэлт дүгнэлт гаргаж байснаас биш яг Инновацийн тухай хуульдаа 2016 онд батлагдсан ЗГ-ын аргачлалын дагуу бол огт юу хэрэгжилт, үр дагаврын үнэлгээ хийгдээгүй байсан гэж бид нарын судалснаар гарч байгаа. Яагаад зөвхөн Инновацийн тухай хуулиа бүхэлд нь аваагүй юм бэ гэхлээр Хууль тогтоомжийн тухай хууль дээр хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхдээ тодорхой зүйл, заалт, хэсгийг сонгож авна гэж заасан байгаа. Тэгээд тэр сонголтынхоо хүрээнд тодорхой саналаа өгөөд тэгээд гэрээнийхээ ажлын даалгаврын хүрээнд л боловсруулсан ийм байгаад байгаа. Яг хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ нь яг тодорхой зүйл, заалтыг л сонгож авч хийдэг учраас тэгээд сонгосон зүйл, заалтууд нь тэгээд яг нөгөө санхүүжилттэй холбоотой болон урт хугацааны болон юутай бодлого төлөвлөлттэй, хөтөлбөртэй холбоотой хэсгүүдийг нь сонгож аваад тэгээд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн байгаа.

Ж.Золжаргал: Энэ дундуур нь энэ хуулийн хэрэгжилтийн талаар ямархуу бодолтой байгаа талаар Ганзориг доктор МУИС-ийн доктор Ганзориг доктороос санал сэтгэгдэл сонсчихъя гэж бодлоо. Тэгээд анхны хууль дээр ажиллаж байсан судлаач хүний хувьд, тэр юун дээр очоод нэг дугаартай микрофон дээр, 3 дээр очоод та ярьчих уу, 4 минутад сэтгэгдэл хэлнэ үү.

Ч.Ганзориг: Сайн байцгаана уу. Тэгэхээр 2012 онд энэ хууль батлагдахад МУИС-ийн дэд захирлын албан үүргийг гүйцэтгэж байсан. Тэгээд түүн дээр МУИС-ийн багийг ажиллаад ажиллаж байсан юм. Энэ хуулийг хэлэлцүүлэх явцад Шинжлэх ухааны паркийн тухай дэд хэсэг, мөн тусгай сан ялангуяа венч сан, ... сангийн чиглэлийн орсон хэсгүүд бол хэлэлцүүлгийн явцад хасагдаж байгаад хууль ерөнхийдөө яах вэ тэр үед харьцангуй шинэ хууль байсан учраас нэлээд зүйл хасагдсан байгаа юм. Тэгээд энэнээс хойш яг холбогдох хууль болон тодорхой журмууд нэлээн удаашралтай гарсан. Засаг төр нэлээн олон солигдсон. Тэгээд энэ бол нэлээн гээгдсэн байгаа. Ингээд 19 онд болохоор нэг нэмэлт, өөрчлөлт орсон. Түүн дээр түрүүн энэ ажлын хэсгээс ингээд ярилаа. Тэгэхээр хуулийн яг хэрэгжүүлэлт нийт утгаар нь аваад үзэхэд Их сургууль.../минут дуусав/

Ж.Золжаргал: 3 номер нэмээд өгнө үү.

Ч.Ганзориг: Их сургуулиудын түвшинд болон аж үйлдвэрийн салбарын хувьд нэлээн хэрэгжилт удаашралтай байсан. Ерөнхийдөө анх гарч байх үед Инновацын тухай хууль бол эдийн засаг, нийгмийн баялгийг, бүтээмжийг хамгийн өндөр түвшинд байлгахад зориулагдсанаар их сургууль, аж үйлдвэрийн хамтын ажиллагааны бодлогын судалгаа гарсны үндсэн дээр түүн дээр тулгуурлаад гарч байсан учраас миний яг судлаачийн зүгээс харахад одоогийн байдлаар 2 зүйл дутагдаад байх шиг харагдаж байгаа юм. 1 дүгээрт нь болоод ирэхээрээ үйлдвэр технологийн паркууд мега төслүүд гараад ирчихсэн тохиолдолд нэг талаас аж үйлдвэр нэлээн хүчтэй менежменттэй орж ирж байна. Нөгөө талд инновацын нэг гол хэсэг болох шинжлэх ухааны парк, энэ дотроо ... сургуулиуд, судалгааны хүрээлэн төвүүдийн асуудлууд их сургуулиуд дээр маш хүндрэлтэй байж байгаа учраас хүний нөөцийн асуудал, мөн оюуны өмч, стандартын асуудлуудыг үйлдвэр технологийн паркт нийлүүлэлт нэлээд дутагдах ийм хандлагатай байгаа учраас Инновацын хуулийн хүрээнд эсвэл шинжлэх ухааны Шинжлэх ухаан, технологийн хуулийн тулгуур хууль дээр инновацыг нэмэх эсвэл тусад нь гаргах 2 зам байна уу, яг хуучнаараа явах гэсэн нэг ийм 2 зам байж байгаа.

Тэгээд энэ дээр болохоор Шинжлэх ухааны паркийн эрх зүйн тухай байдлын хуулийг Их сургуулиудын болон Боловсролын ерөнхий хууль, Шинжлэх ухаан, технологийн хуультай холбогдуулан нэн яаралтай гаргах шаардлага байж байгаа. Энэ дээрээс аж үйлдвэрийн салбар ялангуяа 6 үйлдвэр технологийн парк мега төслүүд хэрэгжиж байгаа тохиолдолд инженерийн хүний нөөц нэлээн их эрэлттэй байгаа тохиолдолд шинжлэх ухааны паркаар дамжуулж аж үйлдвэрийн буюу энэ хүний нөөцийн энэ их мэргэжилтний эрэлт хэрэгцээг ийм хангах шаардлага байна гэж харж байгаа. Өөр нэг нэмээд хэлэх зүйл болоод ирэхээр их сургуулиудын яг бодит байдлыг үзэхэд.../минут дуусав/

Ж.Золжаргал: Баярлалаа, мэдээлэл авлаа. Цэнгүүн гишүүний асуултыг сонсьё, микрофон нээж өгнө үү.

С.Цэнгүүн: Энэ Инновацын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй гэдэг дүгнэлт гарсан байгаа юм байна. Тэгээд ажлын хэсгийн дүгнэж байгаагаар болохоороо санхүүжилтгүйн улмаас л ерөөсөө энэ хууль маань сайн хэрэгжиж чадахгүй байгаа юм байна гээд ярьж байна. Тэгээд энэ санхүүжилтийнх нь асуудлыг ер нь бүх мөнгө нь Шинжлэх ухаан, технологийн сангаасаа гараад явж байгаа юм байна гэдэг ойлголт сая авлаа. Тэгээд энэ сан дээр болохоороо 941 төслийг 22,6 тэрбум төгрөгөөр зарцуулсан юм байна. Тэгээд энэ чинь нэг төсөлдөө хуваагаад үзэхээр 24 сая төгрөг нэг төсөлд зарцуулсан байгаа юм. Тэгэхээр ер нь 941 төслийг бид сонгон шалгаруулж аваад явуулаад байгаа нь хэр оновчтой юм бэ? Энэ инновац шинжлэх ухаан гэдэг чинь өөрөө ямар том өртөг зардалтай байдаг билээ. Нэгд энэ дээр тооны хувьд асуулт байна.

2-т болохоороо энэ сонгон шалгаруулалтыг нь болохоороо Боловсролын яаман дээр Шинжлэх ухааны нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар дээр шийддэг байсан юм байна, тэгж явдаг байсан. Одоо Эдийн засгийн хөгжлийн яам руу шилжүүлсэн байна. Тэгээд энэ сонгон шалгаруулалт нь яаж явдаг нь тодорхойгүй. Энэ ЗГ-ын тусгай сангууд гээд жижиг, дундын ЖДҮ сан байна, Боловсролын зээлийн сан байна, энэ ШУТ сан гээд ороод. Энэ ШУТ сан дээр сүүлийн 2, 3 жил Аудитын газраас хязгаарлалттай дүгнэлт гаргачихсан байгаа. Ердөөсөө үйл ажиллагаа нь хангалтгүй гэдэг нь аудитаар батлагдчихсан. Зориулалтаар мөнгө нь ашиглагдаагүй байна гэдэг нь гарчихсан ийм сангийн тухай бид өнөөдөр яриад сууж байна л даа. Тэгэхээр одоо яах юм бэ, хэн хариуцлага хүлээх юм бэ? Бид энэ асуудлыг зайлшгүй гаргах ёстой. Энэ төслүүдийн сонгон шалгаруулалт чинь уг нь олон нийтэд нээлттэй байгаад оюутан, залуучууд, шинэ start up-ууд ингээд бид шинэ юмнуудыг дэмжиж гаргаж ирэх гээд л явуулаад байгаа болохоос биш нэг хуучны л нэг багш нар, доктор, профессорууд дунд явдаг нэг ийм сан болоод хувирчихсан шүү дээ. Энэ ерөөсөө нууц биш. Хүмүүс бүгдээрээ мэдэж байгаа ийм асуудал байгаа юм.

Тэгэхээр энэ Инновацын байнгын хороон дээр бид ер нь энэ Шинжлэх ухаан, технологийн сангийн тухай асуудлыг оруулж ирж яримаар байна. Ер нь ингээд хаана хаанаа аудит нь хүртэл дүгнэлтээ гаргачихсан байна. Ажлын хэсэг энэ хууль хэрэгжилт нь хангалтгүй юм байна гээд дүгнэлтээ гаргачихлаа. Тэгвэл шийдвэр гаргагчид нь одоо шийдвэрээ гаргая л даа. Хариуцлага тооцох ёстой хүмүүстэй нь хариуцлагаа тооцъё. Цаашид тэгвэл дахиж ийм алдаа гаргахгүйгээр яаж сонгон шалгаруулалтыг явуулдаг байх ёстой юм. Бид сонгон шалгаруулалтаа хийж чадахгүй байгаа юм бол тэгвэл төсвөөс энд бид мөнгө тавиад байх шаардлагатай юм уу, үгүй юм уу гэдэг асуудлаа ч гэсэн ярих шаардлагатай. Тэгэхгүй ингээд нэг хэсэг мөнгө тавьчихдаг, тэгээд тэрнийгээ ямар ч үр дүнгүй зарцуулчихдаг. Тэгснийх нь араас нь болохоороо бидэнд дахиад мөнгө дутчихлаа гээд ороод ирдэг ийм асуудлыг бид цаашид үргэлжлүүлээд яваад байхгүй. Тэгэхээр энийг Инновацын байнгын хороон дээр бид авч үзээд, энэ Шинжлэх ухаан, технологийн санг яах юм гэдэг тал дээр маш хатуу байр сууриуд, дээрээс нь чиглэлүүд гаргаж явмаар байна. Тэр байр сууриа өнөөдөр хэлье гэж бодож байна.

Ж.Золжаргал: Шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагаатай энд байгаа хүмүүсээс хамгийн сайн танил нь Баттогтох дарга байх. Тэгэхээр гүйцэтгэл, үр дүн, ер нь цаашдаа яаж сайжруулъя гэсэн нэг тийм баримталж байгаа бодлого та бүхний дунд яаман дээр байгаа байх. Тэр талаар мэдээлэл өгнө үү. Ер нь энэ сангийн гүйцэтгэл, үр дүнгийн талаар тусдаа мэдээлэл сонсъё гэдэг Цэнгүүн гишүүний саналыг дэмжиж байна. 6 номер.

Д.Баттогтох: Шинжлэх ухаан, технологийн сангийн тухайд энэ сан нь шинжлэх ухаан, технологи, инновацын үйл ажиллагааг санхүүжиж байгаа ер нь үндсэн ганц сан нь. Тэгэхээр энэ дээр яах вэ гол нь судалгаа хөгжүүлэлтийн зардал энэ сангаар дамжиж санхүүжүүлдэг. Сангийн үндсэн зорилго бол шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг дэмжихэд, түүнтэй холбоотой төсөл хөтөлбөр, арга хэмжээг дэмжихэд чиглэсэн ийм тусгай сан байгаа юм. Тэгэхээр энэ сангийн тухайд сүүлийн 10 жилийн гэдэг юм уу дунджаар авбал нөгөө ковидын үед нэг жилд бараг 2 орчим тэрбум төгрөг зарцуулсан. Зарим өсөлттэй жилдээ 10 орчим тэрбум зарцуулдаг. Тэгэхээр энэ өөрөө сангийн зорилго нь дахиад давтаад хэлэхэд яг судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхэд чиглэгддэг. Тэгэхээр судалгаа хөгжүүлэлт дээр суурь судалгаа орно, хэрэглээний судалгаа орж байгаа, технологи хөгжүүлэлтийн судалгаа орж байгаа. Инновацын төслүүд бол сүүлд Инновацын тухай хууль саяын зохицуулалтаар нэмж орсон байгаа юм.

Тэгэхээр сангийн тухайд үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд зарцуулалтуудаа хийгээд, харьцангуй энэ зарцуулж байгаа төсвийг нь саяын судалгаа хөгжүүлэлтийн энэ 3 бүтцээр аваад үзвэл 30, 30, 30 гэсэн ийм харьцаатай үндсэндээ байгаа, яах вэ урт хугацааны дунджаа аваад үзвэл. Инновацын зардал өөрөө төсөв дээр судалгаа хөгжүүлэлтийн зардлаас гадна өндөр технологи, инновацын зардал гэж тусдаг. Энэ зардалтай холбоотой сая тоог сүүлийн 13 жилийн үгүй ээ, 2013 оноос гарсан тоо нь надад байгаа. Тэгэхээр энэ дээр нийтдээ яг инновац дээр 17,6 тэрбум төгрөг зарцуулсан байгаа. Тэгэхээр яах вэ үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд сан тодорхой үр ашигтай ажиллаж байна гэж бид харж байгаа. Тэр аудитын дүгнэлттэй холбоотой асуудал бол хуультай холбоотой нэмэлт, өөрчлөлтүүд, өөрөөр хэлбэл энэ сан зөвхөн төсөл хөтөлбөр биш, шинжлэх ухааны үйл ажиллагааг дэмжих ёстой, өөрөөр хэлбэл түгээн дэлгэрүүлэлт, тэгээд шинжлэх ухааны боловсрол олгох, бусад ийм шинжлэх ухааны соёлыг дэмжсэн олон арга хэмжээнүүд рүү зарцуулагдах ийм бололцоотой байгаа юм. Тэгээд тэр агуулга нь сангийн үр дүн сайн, муу гэдэг нөлөөлөлд нөгөө шинжээчдийн дүгнэлтээр янз бүрийн юм гараад байгаа л гэж бодож байгаа. Бид нарын зүгээс харахад шалгаруулалтаа төслийн сонгон шалгаруулалтыг сайжруулсан. Одоо бол хүнээс хараат байх тэр хэлбэрүүдийг нь илүү хязгаарласан. Тэгээд энд хувийн хэвшил, хувь хүн, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага бүгдээрээ нээлттэй.../минут дуусав/

Ж.Золжаргал: Хариулт 4 номер нэмж хариулах юм уу? 4 номер.

Д.Баттогтох: Судалгааны дүгнэлт бол Инновацын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй гэж гарсан. Энэтэй холбоотой санхүүжилт зөвхөн нэг хэсэг нь байгаад байгаа. Яг санхүүжилттэй, зөвхөн санхүүжилтээс шалтгаалаад хангалтгүй биш. Мөн удирдлага зохион байгуулалт, бодлого төлөвлөлт, урт, дунд болон богино хугацааны бодлого төлөвлөлт нь хоорондоо зөрчилдсөн, байхгүй, хэрэгжихгүй байгаа. Мөн батлагдан гарах хуулийг яг бодит байдлаар хэрэгжүүлэх нарийвчилсан зохицуулалттай батлагдан гарах ёстой журмууд нь өөрөө батлагдаагүй. Батлагдсан журмууд нь тодорхой хуулийн зөрчилтэй байгаад байна. Тэгэхээр нийтлэг байдлаараа ер нь ингээд нийтдээ бол хангалтгүй байна гээд дүгнэж байгаа. Мөн санхүүжилтийн хувьд мөн хангалтгүй талаар сая хэлчихсэн. Тийм. Нийтлэг, ингээд бүх зүйлийг нь ингээд хараад үзвэл хангалтгүй байна л гэж дүгнэлт өгч байгаа.

Ж.Золжаргал: Цэнгүүн гишүүний асуусан энэ ШУТ сангийн юу нөгөө боловсрол, шинжлэх ухаан, соёл, илүү Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын

хороо нэгдсэн байдлаар сонсох юм уу, ямар ч байсан бичгээр юмаа авчхаад, тэгээд дараа нь хамтарсан байдлаар сонсох нь зөв болов уу гэж бодогдож байна. Баярлалаа. Рэгдэл гишүүн асуултаа асууна уу.

Д.Рэгдэл: Баярлалаа. Энэ Инновацын хуулийн хэрэгжилтийг нэг үзээдхээсэй л гэж бодоод байсан. Тэгээд ямар ч байсан нэг үзсэн юм байна сөхөж, сөхөж харсан бололтой байна. Тэгэхдээ ЗГ-ын аргачлал байдаг юм байна гэж ойлголоо. Тэрүүгээр хийгээд дүгнэлтүүд гарсан байна. Яах вэ энэ 4 дүгнэлттэй бол би санал нэг байгаа юм. Тэгэхдээ энэ аргачлалаар хийхэд ер нь хэрэгжилт нь тэдэн хувь орчим юм байна гэж тооцож болдог юм уу, үгүй юу гэдэг ийм нэг асуулт байгаа юм.

Инновацын хуулийн энэ анхдагч хууль 12 онд батлагдахад энэ Ганзориг багш бид 2 лав ажлын хэсэгт нь байсан. Тэгээд 12 оны сонгуулийн өмнө нэлээн яаралтай баталчихсан. Тэр үед чинь сонгуулийн хугацаа их урт байсан тийм учраас нэлээн эрт чуулган ажлаа дуусгадаг байлаа. Тэгээд янз бүрийн шалтгаантай. Тэгэхдээ яг энэ хуульд орсон яг амин сүнс нь болсон хэсгийг ингээд 13 оноос эхлээд ингээд хасаж танасаар байгаад одоо бол энэ нэг бурхан гэж бодвол шүншиггүй болчихсон нэг тийм л хууль санагдаад байгаа юм. Яагаад вэ гэвэл ерөөсөө санхүүжилтийн тухай асуудал байхгүй. Тэр венч сангийн тухай бүхэл бүтэн бүлгийг ганцхан удаа ингээд хасаад хаячихдаг. Дараа жил нь, батлагдсаны дараа жил нь санагдаж байна инновацын тухай Инновацын сангийн тухай заалтыг нь хасаад хаячихдаг. Тэгээд Шинжлэх ухаан, технологийн сангаас алдаг оног ингэж санхүүжүүлээд шинжлэх ухаан, технологийн инновацын төслийг алдаг оног, зарим жил санхүүжүүлээд, зарим жил байхгүй л байгаа шүү дээ. Ингэж яваад нэг л ийм сонин байдалтай ийм төсөл болчихоод байгаа юм.

Тэгэхээр зэрэг одоо энэ хуулийг ер нь агуулгын хувьд шинэчилнэ гэдэгтэй би бүрэн дүүрэн санал нэг. Тэр тусмаа энэ ЗГ-ын үйл ажиллагааны 24, 28 оны хөтөлбөрт Шинжлэх ухааны паркийн тухай хуулийг оруулна гэсэн ажил явж байгаа юм. Тэгээд энэ хууль Паркийн хууль ороод ирнэ, тэгэхээр зэрэг энэ Инновацын тухай хуулиас бас нэг том бүлэг нь байхгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр Инновацын тухай хуулийг юун дээр авч үлдэх вэ гэдэг асуудал гарч ирнэ. Тэгээд шинэчилсэн найруулга бол энүүхэнд байгаад байгаа юм. Ямар ч байсан нэг ингээд үнэлээд үзсэнд баярлалаа.

Тэгээд инновацын дэд бүтэц юугаа аль хаанаа хөгжүүлдэг вэ энэ тэр гээд судалгаа дээр шүүмжилмээр юмнууд байх шиг байна. Энэ инновацын үйл ажиллагааны хэрэгжилтийг үндсэндээ энэ Монголчууд л тоодоггүй болохоос биш хамгийн сайн хийсэн газар бол Хятад. Тэнд Шинжлэх ухааны паркаас өгсүүлээд өндөр технологийн бүс гэсэн 3, 4 давхар бүтэцтэй. Тэгээд хотуудын өндөр технологийн бүтэц бол.../минут дуусав/

Ж.Золжаргал: Та нэмэлт минут авах уу? Рэгдэл гишүүний нэмэлт минутыг өгнө үү, микрофон нээж өгнө үү.

Д.Рэгдэл: Тэгээд Япон жишээлбэл инновацын асуудал их сургууль дээрээ түшиглэдэг гээд л тэгэх юм. Энэ бас л өрөөсгөл юм байгаа юм. Энийг зүгээр яах вэ судалгааны салбарын улсууд бол судалж тодруулах ёстой. Тэгэхээр манайд инновацын дэд бүтцээс жаахан явж байгаа нь start up гэдэг. Start up яагаад явахгүй байна вэ гэдгийг би бол энэ инновац хариуцсан яамны хүмүүсээс асуумаар байгаа юм улсын яамнаас. Тэгээд хамгийн гол асуудал манай шинжлэх ухаан, технологийн салбарын хамгийн эмзэг цэг нь санхүүжилтийн ганцхан эх үүсвэртэй байгаад байна

гэдгийг ЮНЕСКО-ийн экспертүүд 2 удаа гаргаад ирчихсэн. Тэгээд тэр ганц эх үүсвэр нь сан байгаад байдаг. Тэгэхээр өөр эх үүсвэр гаргах тал дээр цөмөөрөө хамтарч ажилламаар байгаа. Тэгээд энэ 2 асуултад хариулж өгөөч. Биелэлтийн хувь, дараа нь start up-ууд яагаад хөгжихгүй байна гэдэг шалтгааныг олох ёстой шүү дээ.

Ж.Золжаргал: Судалгааны байгууллага эхлээд хариулъя 4 номер.

Б.Жавхлан: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Тэр нөгөө яг хувьчилж биелэлтийг гаргаж болдог уу гээд. Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйл дээр яг энэ нөгөө үр дагаврын үнэлгээг бол дурдсан байж байгаа. Үр дагаврын үнэлгээ дээр тухайн зүйлээс тодорхой нөгөө төлөөлөл бүхий тодорхой зүйл, заалтыг сонгож аваад, яг тухайн сонгож авсан зүйл, заалт нь бодит байдал дээр зорилгодоо хүрсэн үү, хэрэгжсэн үү гэдэг, хэрэгжсэн үү, хэрэгжээгүй юу гэдэг нь 1 л дүгнэлт, 2 л дүгнэлт оруулдаг учраас тодорхой хувиар бол үнэлэх боломжгүй. Хэрэгжээгүй гэдэг бол манайхаас тийм дүгнэлт гарч байгаа.

Ж.Золжаргал: 3 номер дээр саяын start up-уудыг дэмжих талаар.

Б.Бат-Өлзий: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Start up яг start up мэдээж хөгжих боломж нь түрүүний нөгөө коммунити буюу coworking орчныг бүрдүүлэх тал дээр бид яг тодорхой бүрэн яг дэмжихгүй байгаа нэг ийм асуудал байгаа. 2 дугаарт Венчур fund та өөрөө хэллээ. Венчур сангийн асуудал үеийн үед ярьсаар л ирсэн өнөөдөр хүртэл яг Венчур сангийн асуудал бол бид ердөө шийдэхгүй явсаар. Венчур сан байхгүй тохиолдолд энэ start up нэг тодорхой хэмжээнд хүрээд л зогсоно. Тэгээд гадагшаа гарч, гадагшаа бид төрөөс дэмжиж ямар ч байсан гаднын хөрөнгө оруулалтыг оруулж ирж, тэр компанид холбож өгч чадсан нь цаашаа явж байгаа. Тэгээгүй нь явж чадахгүй байгаа угаасаа. Тэгээд нэг тодорхой хэмжээнд хүрээд л зогсчхож байгаа. Тэрнээс хойш ямар ч дэмжлэг байхгүй гэсэн үг. Зөвхөн арга хэмжээгээр нэг байраар тодорхой хэмжээнд дэмжиж байгаа, тэгээд өөр дэмжлэггүй байгаа нь өөрөө энэ start up хөгжихгүй байгаа гол шалтгаан байх гэж бодож байна.

Ж.Золжаргал: Болсон уу та? Би та бүхний дунд нэг ийм асуулт тавьчихмаар санагдаад байна. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль гээд том хууль өнгөрсөн жил нэлээн удаан боловсруулж байгаад гараад ирсэн. Инновацийн тухай хууль маань ингээд 10 гаруй жил олигтой хэрэгжилтгүй явж байдаг. Тэгээд одоо технологи нутагшуулах сандбоксын эрх зүйн орчныг сайжруулах ажлын хэсэг гачихсэн нэг тийм ажлын хэсэг гарчихсан явж байгаа Улсын Их Хурлын. Тэгээд ер нь зүгээр эд нар чинь ингээд нэгтгэчихвэл амар юм биш үү? Заавал тусдаа ийм хууль байх хэрэг байгаа юм уу хэрэгждэггүй? Заалтыг нь өгөөд энэ дээр нэг байр суурь асуулт, энэ талаар хэн хариулах вэ? 6 номер. 6, 4, 3 зүгээр бодлыг нь сонсчихъё тэгэх үү, тэгээд хаалт дүгнэе. 6 номерын микрофон нээж өгнө үү.

Д.Баттогтох: Түрүүн байр сууриа, Байнгын хорооны дарга Золжаргал гишүүний асуултад хариулъя. Тэгээд түрүүн ерөнхийдөө байр суурь илэрхийлсэн Инновацийн хууль чухал хууль. Тэгэхээр энэ хуулийн дутагдалтай, хэрэгжихгүй байгаа, дагалдах хууль дээрээ нэмэлт, өөрчлөлтүүд нь ороогүй, нэр томьёоны, сая гишүүдийн хэлж байгаа хууль батлагдсанаас хойш хассан заалтуудыг сэргээх гээд олон сайжруулах зохицуулалтууд байгаа. Тэрийгээ оруулаад хэрэгжүүлээд явуулбал илүү үр дүнтэй байн байх гэсэн ийм байр суурьтай байгаа.

Ер нь Шинжлэх ухаан, технологийн хууль дээр бол энэ шинжлэх ухааны мэдлэг бий болгохоос үйлдвэрлэл, үйлчилгээ хэрэглээнд нэвтрэх, эцсийн бүтээгдэхүүн гаргах бүх хүрээг ерөнхийдөө харж зурагласан байгаа. Тэгээд энэ бид Солонгосоос бенчмарк хийсэн. Солонгос үндсэндээ Японоос энэ тогтолцоогоо нэвтрүүлсэн ийм байгаа юм. Тэгэхээр ерөнхийдөө Солонгост ... act of science in technology гээд ерөнхийдөө суурь хууль гэж нэрлэгдээд, эндээсээ саяын тэр чөлөөт бүсүүдийн, тэгээд хиймэл оюун, инновац, шинжлэх ухааны парк гээд бүх хуулиуд нь энэ хуулийнхаа суурь зарчимтай нийцсэн зохицуулалтуудыг хуульчлаад гаргасан байдаг юм байна лээ. Тэгэхээр тэр агуулга талаасаа бид иймэрхүү зохицуулалтаар явбал илүү үр дүнтэй байх болов уу гэж харж байна. Шинжлэх ухааны паркийн тухай хуульд хөрөнгө оруулалт гээд олон асуудлуудыг, паркийн хэв шинж гээд олон асуудлуудыг зохицуулах учраас тусдаа хуулиар зохицуулах нь илүү үр дүнтэй байх болов уу гэж бид харж байгаа.

Ж.Золжаргал: 4 номер дээр жишээ авсан олон улсын туршлагаас харахад Шинжлэх ухаан, технологийн хуулиараа инновацаа зохицуулдаг юм байна, тусдаа байхгүй. Гэхдээ бид тусдаа байвал зүгээр юм шиг байна гэсэн дүгнэлт хийсэн байсан. Тэгээд энийг дахиад нэг тайлбарлаад өгөөч. Яагаад бусад улс дээр нэг байхад, бид тусад нь байсан нь зүгээр гэж үзэж байгаа юм.

Б.Жавхлан: Яг таны хэлсэнчлэн дүгнэлтийг хийсэн байгаа. Бусад улсуудын хууль бол, хувьд ерөнхийдөө Шинжлэх ухааны тухай хуульдаа багтаад явж байгаа. Манай хууль бол Инновацийн тухай хууль 2012 онд батлагдаад муу ч үгүй 13 жил хэрэгжээд, тодорхой газар, хэлтэс бүтэц юмнууд нь байгуулагдаад ажиллаад явж байгаа. Тэгэхлээр манай судалгааны багаас гаргасан зүйл бол яах вэ анхнаасаа гаргахдаа Инновацийн тухай хуулийнхаа асуудлыг бол Шинжлэх ухааны тухай хуульдаа багтаагаад явбал зохилтой байсан. Одоо нэгэнт өнгөрсөн учраас одоо байгаа хуулиа засан сайжруулах талаар яриад явах нь зүйтэй байх гэж байгаа. Яагаад гэхлээр байгаа юмыг байхгүй болгох нь өөрөө аягүй хэцүү зүйл учраас одоо байгаа зүйлээ засан сайжруулаад явах нь илүү үр дүнтэй юм болов уу л гэдэг тийм дүгнэлт дээр ирж байгаа юм.

Ж.Золжаргал: Улсын Их Хурлын гишүүдээс нэмж үг хэлэх үү? Рэгдэл микрофоныг нээж өгье. Үг хэлэх гишүүдээс Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Сая таны асуулттай холбогдуулж хэлэх гэж байгаа юм түүнээс. Тэгэхээр энэ хуулийн хувьд хэд хэдэн хувилбар байж болмоор байгаа юм. Ер нь дэлхийн олон оронд Шинжлэх ухааны тухай хууль гэж байгаа. Тэгэхээр Шинжлэх ухааны тухай хууль гэж нэг хууль бие даасан. Тэгээд бид чинь энэ Инновацийн тухай хууль дээр ерөнхийдөө зөвхөн технологийн инновацыг л яриад байгаа шүү дээ дандаа, бусад инновацын тухай бол энд байхгүй. Тэгэхээр Технологи, инновацын тухай хууль гэдэг 2 дахь хууль байж болно гэж бодогддог.

Өөр нэг хувилбар ер нь Шинжлэх ухаан, технологи, инновацын тухай хууль гээд нэг хууль байж байхад болохгүй юм бол байхгүй. Яагаад вэ гэвэл энэ Шинжлэх ухаан, технологийн тухай энэ 24 онд батлагдсан шинэчилсэн найруулга дээр шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа гэдэг нэр томъёоны дор инновацыг оруулчхаад байгаа юм. Яагаад гэвэл мэдлэг, технологи, инновац гэсэн энэ цикл яваад байгаа юм чинь. Тэгэхээр зэрэг энэ Шинжлэх ухаан, технологийн тухай хуультайгаа нийлүүлээд Шинжлэх ухаан, технологи, инновацын хууль гэдэг хувилбар бол бас болмоор байгаа юм. Болохгүй юм ерөөсөө байхгүй. Тийм учраас манай Инновацийн байнгын хороо, Боловсрол юуны тэр урт нэртэй байнгын хороо

нийлж нэг хуралдаж байгаад, энийг судлах ажлын хэсэг гаргачихмаар байгаа юм. Тэгээд ямар хувилбар зүгээр байна вэ гээд тохироод. Гол нь энэ сонирхлыг нь хөнддөг талуудтай маш сайн ярилцмаар байгаад байгаа шүү дээ, оролцогч талуудтай. Тийм саналтай байна. Золжаргал дарга санаачилга гаргаад, манай Ундрам даргатай ярьж байгаад нэг яриадахвал болж л байна, орж болж байна.

Ж.Золжаргал: Мэдээлэл өгсөн Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, судалгааны байгууллага, ажлын хэсгийн яамдын төлөөлөл нартаа баярлалаа. Товчхон дүгнээд хэлбэл ийм зураг харагдаж байна. 2012 онд Инновацын тухай хууль гээд гоё хууль батлагдсан, хэрэгжилт нь хангалтгүй байна. Санхүүгийн эх үүсвэрүүдтэй сангуудыг тусгасан байсан тэд нарыг нь нэмэлт, өөрчлөлтөөр бүгдийг нь хасчихсан. Дагалдан гарах журмууд нь батлагдаж бүрэн дуусаагүй, дагалдах хуулиудын өөрчлөлтүүд шаардлагатай байгаа гэж үзэж байгаа. Гэхдээ энэ нь хийгдээгүй байна. Өнгөрсөн хугацаанд үнэлгээ, хэрэгжилтийн үнэлгээ хийгдээгүй байна. Хууль тогтоомжийн тухай хуулиар хуучин салбарын бодлогын баримт бичгүүд нь цуцлагдаад, шинэчлэгдээд, дунд хугацааны хөтөлбөр гарч ирэх ёстой байсан, тэр хөтөлбөр нь гараагүй юм байна.

Тэгэхээр цаашдаа яаж явах вэ гээд нэг ийм асуулт гарч ирж байгаа юм. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль гээд том хууль баталсан байна. Шинжлэх ухааны паркийн тухай хууль батлагдана гээд ЗГ-ын хөтөлбөрт орчихсон байна. Улсын Их Хурлын энэ сандбокс шинэ технологи нутагшуулах тухай ажлын хэсэг эрх зүйн орчныг сайжруулах ажлын хэсэг гээд гарчихсан байж байдаг. Тэгээд энэ Инновацын тухай хууль байна. Тэгэхээр эд нарыг нэгтгэх, алийг нь алинтай нь нэгтгэх, эсвэл тус тусдаа байх уу гэдэг нэг ийм асуулт.

2 дахь нь болохоор хэрэгжүүлээд эхлэхээр нөгөө хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллага гэдэг асуулт дахиад л босож ирэх юм байна. Эдийн засгийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Боловсролын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, бас нэг юуны Инновац, шинжлэх ухаан, технологийн үндэсний хороо. Тэгэхээр энэ субъектүүд маань хэн нь юугаа хариуцах вэ, яаж хамтарч ажиллах вэ гэдгийг Засгийн бүтцийн асуудал гээд үлдээж бол болохооргүй харагдаж байна. Тэгэхээр Инновац, цахим бодлогын байнгын хороо, Шинжлэх ухаан, соёл, боловсролын байнгын хороо хамтарсан байдлаар бид гишүүд эхлээд хоорондоо ярилцаж байгаад, тэгээд хурлын төлөвлөгөө, дэг, товоо тогтож байгаад, тэгээд энэ асуудлыг ер нь нэг ярих нь зүйтэй юм байна. Тэрнийхээ дараагаар эрх зүйн орчныг сайжруулах ажлын хэсэг Инновацын хуулийг шинэчлэх үү, нэмэлт, өөрчлөлт, нөгөөдүүлтэй нь нэгтгэх үү, дээрээс нь бүтцийн асуудал дээр байр сууриа илэрхийлээд, тодорхойлоод тавих ёстой гэж тийм зүйл өнөөдөр харагдаж байна. Тэгээд энийг албан ёсоор ингээд бид хурлаар шийднэ. Та бүхэндээ оролцсонд баярлалаа. Маш их үнэ цэнтэй мэдээлэл өглөө гэж үзэж байна.

15.37 цаг

Хэлэлцэх асуудал дууссан тул Инновац, цахим бодлогын байнгын хорооны хурал дууссаныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА